

Mongolian Economy

2025 оны 12 сар (202)

www.mongolianeconomy.mn

Зочин

С.Дэмбэрэл: Өрхийн эдийн засаг сайжирч байж үндэсний эдийн засаг хүчирхэгжинэ

Төсөв

Их наядын алдагдалтай төсөв




ЭДИЙН ЗАСГИЙН АРХИТЕКТОР

МҮХАУТ-ЫН ДАРГА АСАН,
ЭДИЙН ЗАСАГЧ С.ДЭМБЭРЭЛ

FURSYS БРЭНДИЙН АЛБАН ЁСНЫ ТӨЛӨӨЛӨГЧ АНУН

Fursys бол ажлын орчныг сайжруулахын тулд сайн чанарын бүтээгдэхүүн, оффис шийдлүүдийг санал болгодог дэлхийд тэргүүлэгч компаний нэг юм. Орчин үеийн загварлаг ашиглалт сайтай, өнгөлөг Fursys брэндийн оффис тавилгууд нь зөвхөн хийцлэлдээ анхаарах бус ашиглалтыг дээд зэргээр хангаснаараа онцлогтой



7777-8181



ХУД 3-р хороо Чингисийн өргөн чөлөө
MCS байр Анун төв

АНУН КОМПАНИЙ ТУХАЙ

Монголд оффис, гэрийн орчинд тохирсон чанартай тавилгын эрэлт сүүлийн жилүүдэд эрс өсөж байна. Энэхүү хэрэгцээнээс урган гарсан дотоодын брэнд бол Анун тавилга юм. Тус компани нь загвар, чанар, хэрэглэгчийн бодит хэрэгцээг нэг цэгт төвлөрүүлсэн шийдлүүдээрээ ялгарч, “Ажил • Гэр • Аз жаргал” уриатайгаар 28 дахь жилдээ тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.



Анун тавилга нь чанартай, удаан эдэлгээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн зэрэгцээ байгаль орчинд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэлийг эрхэмлэдэг. Үүний бодит илэрхийлэл болгон 2025 онд Монголын тавилгын салбарт анхдагч болж, ISO 9001:2015 (Чанарын удирдлагын тогтолцоо) болон ISO 14001:2015 (Байгаль орчны удирдлагын тогтолцоо) стандартыг албан ёсоор

АНУН тавилгын үйлдвэр нь жилд дунджаар 54,000 м², өдөрт 200 м² тавилга үйлдвэрлэх хүчин чадалтай. Хэрэглэгчийн хүссэн өнгө, загвар, хэмжээ, орон зайн онцлогт нийцүүлэн захиалгат тусгай тавилга үйлдвэрлэдгээрээ Монгол дахь оффисын тавилгын үйлдвэрлэлтэй цор ганц компани

Үйлдвэрлэл нь ХБНГУ-ын хагас автомат, орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон бөгөөд энэ нь бүтээгдэхүүний нарийвчлал, тогтвортой чанар, хугацаанд нь гүйцэтгэлтийг хангах үндэс болдог. Анун тавилга ийнхүү дотоодын үйлдвэрлэлийн чадавх, олон улсын стандарт, хэрэглэгч төвтэй хандлагыг хослуулан Монголын оффис, гэрийн орчныг илүү тав тухтай, бүтээмжтэй болгоход хувь нэмрээ оруулсаар байна.

Борлуулалт

(1 жилд болруулдаг тоо)



7219



4176

БИДНИЙ НИЙТ ТОХИЖУУЛСАН ТАЛБАЙ

2025 ОНЫ БАЙДЛААР



36 ШИРХЭГ CENTRAL
TOWER-ТЭЙ ТЭНЦЭНЭ.



Агуулга



Эрхлэгчийн зурвас 05
Mongolian Economy эдийн засагч С.Дэмбэрэлийг онцоллоо

Онцлох сэдэв 06
Савлагаанд сэгсрэгдсэн эдийн засаг, самуурсан улс төр

Төсөв 7
Их наядын алдагдалтай төсөв

Хөрөг 13
Эдийн засгийн архитектор

Зочин 16
С.Дэмбэрэл: Өрхийн эдийн засаг сайжирч байж үндэсний эдийн засаг хүчирхэгжинэ

Дурсамж 24
Танхимыг хариуцсан сэтгүүлч Танхимын сэтгүүлч болсон нь

Хүнсний хувьсгал 24
Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа бэхэжсэн нь

Аялал жуулчлал 30
Монголын аялал жуулчлалын үнэ цэн

НҮБ 36
Яап ван Хиердэн: Хариуцлагатай аялал жуулчлалыг хөгжүүлснээр экосистемд ирэх дарамт буурна

Шинэчлэл 40
БОНЗ-ын гэрчилгээтэй анхдагчдын нэг "Сүү" ХК

Сурвалжлага 44
Хар тэнгисийн эрэг дээрх монгол залуусын цугларалт

Санхүүгийн боловсрол 48
Анна Нгуен: Бид Австралид амжилттай, найдвартай ирээдүй рүү хөтлөхөд үргэлж бэлэн байх болно



Mongolian Economy

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ: Д.БЭХБАЯР (9999 4248) | РЕДАКТОР: Н.ЭНХБАЯР (9916 1303) | АНГЛИ РЕДАКТОР: РОБЕРТ ЙОХАН ШРАЙВЕРС
СЭТГҮҮЛЧИД: У.САРАНГЭРЭЛ | Б.ШҮРЭНЧИМЭГ | ОРЧУУЛАГЧ: М.АРИУНЗАЯА | ДИЗАЙНЕР: Ш.ОЮУНДАРЬ | МАРКЕТИНГИЙН АЛБА: 9409 2904

ISSN 2664-195X

E-mail: info@mongolianeconomy.mn | FACEBOOK: Mongolian Economy | TWITTER: EconomyMongolia

Эрхлэгчийн зурвас

Mongolian Economy эдийн засагч

С.Дэмбэрэлийг онцоллоо



Д.БЭХБАЯР
Ерөнхий Эрхлэгч

Mongolian Economy сэтгүүл 2025 оны сүүлийн дугаараа уншигч танаа хүргэж байна.

2025 он Монгол Улсын эдийн засгийн хувьд хүндхэн жил болж өнгөрч байна. Улстөрийн тогтворгүй байдал үргэлжилж, 2024 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд гарч ирсэн УИХ-ын дарга, Ерөнхий сайд нар огцорч, Н.Учрал, Г.Занданшатар нар парламент болон засгийг удирдаж байна. Ардчилсан нам хамтарсан засгаас гарч, сөрөг хүчний үүргээ дангаар явуулж эхлэв.

Эдийн засгийн хувьд томоохон сорилттой оны босгон дээр нүүр туллаа. Түлш, шатахууны асуудал 2025 оны туршид асуудал байсаар шинэ онтой золгож байна. Монгол Улсын хамгийн том мега Оюутолгойн төслийн үр дүнгийн талаар УИХ-д Хянан шалгах түр хороо байгуулагдаж, Оюу толгойн сэдвээр сонсгол явууллаа. Эцсийн дүгнэлтээр Оюутолгойн гэрээний алдаа оноог засч залруулах, илүү сайжруулах шаардлагатай байгааг тэмдэглэсэн. “Оюу Толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар анхны монгол хүнийг томилсон онцлог дор энэхүү сонсголын арга хэмжээ болсон юм.

Байгаль дэлхий цасан өмсгөлөө харин Улаанбаатар хот утаан өмсгөлөө өмссөн өвлийн нэгэн өдөр Монгол Улсын төсөв тасалдсан асуудал гарч, олныг гайхшруулав. Засгаас 2025 онд нүүрсээ 100 ам.доллараас давсан үнээр борлуулахаар төсөөлсөн нь бодит байдалд нийцсэнгүй. 2025 оны эхний арван сарын байдлаар 69.7 сая тонн нүүрс экспортолсон бөгөөд нэг тонн тутмыг нь дунджаар 65.0 орчим ам.доллараар борлуулсан гэсэн үг болж байна.

Улсын төсөв тасалдсан асуудал нь хувийн хэвшлийнхний нуруун дээрх ачаа болоод дарамтыг улам ихэсгэв. Төсөв бүрдүүлэх үүднээс татвар, нийгмийн даатгалын өртэй компаниудын дансыг хаах ажиллагааг эрчимжүүлснээр олон мянган аж ахуй нэгж дансаа хаалгав. Энэ бүхэн улсын эдийн засаг, хувийн хэвшлийн санхүү боло өрхийн эдийн засагт нөлөөлж, иргэдийн худалдан авах

чадвар улам муудаж, граммын эдийн засаг руу улам л гулсахад хүргэлээ.

Mongolian Economy сэтгүүл энэхүү дугаарынхаа коверт МҮХАҮТ-ын дарга асан, эдийн засагч С.Дэмбэрэлийг онцолж байна. Тэрбээр 10 гаруй жилийн өмнөөс граммын эдийн засаг, өрхийн эдийн засгийн тухай ярьж, асуудал дэвшүүлж, хуулийн төсөл боловсруулж байсан юм. Өрхийн эдийн засгаа анхаарч, хөгжүүлж байж улс орон хүчирхэгжих талаар түүнтэй 2016 онд хийсэн ярилцлагыг энэхүү дугаартаа орууллаа. Засгийн газар дэд бүтцийн асуудалд илүү анхаарал хандуулж, өрхийн эдийн засгийг орхигдуулж байна. Өөдлөх улс өрхдөө анхаарч, өрхийн эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх шаардлагатай хэмээн ярьсан түүний сонирхолтой ярилцлагыг уншаарай. МҮХАҮТ үүсэн багуулагдсаны 65 жилийн ой энэ онд тохиож буй бөгөөд үүнтэй уялдуулан Танхимын эдийн засгийн харилцааны үндэс суурийг тавьж, босгож, хөгжүүлж бэхжүүлж ирсэн С.Дэмбэрэл даргыг дугаартаа онцлон хөрөг нийтлэл, ярилцлагуудыг хүргэж байгаа юм.

Түүний хувьд Монгол Улсын томоохон эдийн засагч бөгөөд улс орны хөгжлийн төлөвийг 10 болон түүнээс дээш жилээр харж, ярьдаг хүн гэдгийг тодотгож байна. Тэрбээр гэртээ 2000-гаад онд төр, хувийн хэвшлийн түншлэл, ногоон хөгжил, хүрэн эдийн засгаас ногоон эдийн засаг руу шилжих тухай ярьж, сануулж, зөвлөж ирсэн билээ. Харин 10, 20 жилийн дараа л төр хувийн хэвшлийн түншлэл, ногоон эдийн засгийн шилжилтийн тухай бодлогын орчин бүрдүүлэхээр ажиллаж буй жишээг хэлэхэд хангалттай.

2016 оны УИХ-ын сонгуульд дэвшихдээ тэрбээр “Өөдлөх улс өрхөөсөө” уриаг дэвшүүлж, өрхийн эдийн засагтаа анхаарч, хөгжүүлэх тухай анхлан ярьсан юм. Өнөөдөр 2026 он гарч байна. Монголын эдийн засгийн салбарт өрхийн эдийн засгийн тухай ярьж, түүний дэвшүүлсэн санаа оноо, зөвлөмжийг авч ярих цаг ирж буй байх аа.

Онцлох сэдэв

Савлагаанд сэгсрэгдсэн **эдийн засаг**, самуурсан улс төр



2025 оны эхний 10 сарын байдлаар Монгол Улс 69.7 сая тонн нүүрс экспортов

2025 он Монгол Улсын хувьд төрийн бодлого, санхүү, баялгийн засаглал гурвын огтлолцолд үүссэн алдаанууд ил гарч, бодит байдал улстөрчдийн гоё үгийг гүйцэж түрүүлсэн жил байлаа. Монгол Улсын эдийн засгийн бодит байдал болон төсвийн хийсвэр, хэт өөдрөг төсөөлөл хоёрын зөрүү улам тодров. Дэлхийн түүхий эдийн зах зээлийн савлагаа, их гүрнүүдийн худалдааны бодлого, мөргөлдөөн, ялангуяа АНУ, БНХАУ-ын тарифын дайн Монголын эмзэг эдийн засгийг улам донсолгов. Урд хөршийн үйлдвэрлэл агших тусам Монголын экспортын амин судас болсон нүүрсний эрэлт суларч, бидний “хар алт”-аа үнэд хүргэнэ гэсэн найдвар замхрав.

2025 оны эхний 10 сарын байдлаар Монгол Улс 69.7 сая тонн нүүрс экспортов, 4.49 тэрбум

ам.долларын орлого олсон нь нэг тонн тутмыг дунджаар 64.3 ам.доллаар зарсан гэсэн үг. Засгийн газрын зүгээс 100 ам.доллаар давсан үнээр нүүрсээ борлуулна хэмээн төсөөлж байсан нь зах зээлийн бодит байдалтай огт нийцээгүй өөдрөг таамаг байсныг энэ тоо өөрөө илчилнэ. Үүн дээр нэмээд 2025 оны есдүгээр сарын байдлаар чулуун нүүрсний хилийн үнэ өмнөх оноос 37 хувиар унаж, 61.4 ам.долларт хүрсэн нь экспортын орлогын ирээдүй тийм ч гэгээлэг бус байгааг харуулж байна. Эдийн засгийн ийм эмзэг үед Монголын улс төрийн тогтворгүй байдлын “хууч өвчин” дахин сэдрэв.

2025 он гарсаар хоёр Засгийн газар солигдож, төрийн бодлогын залгамж халаа алдагдсаны горьг эдийн засаг шууд амслаа. Төсөв батлах үйл ▶

▶ явц өмнөх жилүүдийн адил маргаан, хэрүүл тэмцэл дунд өрнөж, Ерөнхийлөгчийн хориг, дахин хэлэлцүүлэг, “алдагдалгүй төсөв” гэх улс төрийн уриа бодит байдалтай огтлолцсонгүй.


Монголын Засгийн газар нэг жилийн санхүүгийн зорилгоо ч зөв тодорхойлж чаддаггүй хэвээр байна. Монгол төрийн уламжлал орлогоо хэт өөдрөгөөр төсөөлж, “данхгар төсөв” батлан дараа нь бодит байдалд сөхөрч тодотгол хийдэг болсон.

Тухайлбал, 2022 онд эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц бодлогыг дэвшүүлж хэрэгжүүлсэн. Яг үнэндээ хүссэн үр дүнд хүрээгүй талаар олон нийт, судлаачид ам уралдан мэтгэлцэж байсныг санаж байгаа биз ээ. Гэхдээ 10 их наядын цогц бодлогын эцсийн тайлан нь гайхалтай, сэтгэл сэргэм өндөр өгөөж, өсөлттэй тоон үзүүлэлттэй байсан. Төрөөс гаргаж байгаа тоон тайлангууд нь гоё, амлалт нь том, харин өр, инфляц, ханшийн дарамт нь иргэдийн нуруун дээр буудаг гэж хэлбэл хол зөрөхгүй биз ээ.

Харин 2023 оны төсвийг 1.4 их наяд төгрөгийн алдагдалтай баталсан. Өнгөрсөн хоёр жил урд хөрш маань азаар манайхаас чамлахааргүй их нүүрс худалдан авсны буянд төсөв тасраагүй. Харин 2025 онд 83 сая тонн нүүрсийг 105 ам.доллараар экспортлохоор тооцоолоод байсан. Мөн нийт экспортыг 18.9 тэрбум ам.долларт хүргэж инфляц зургаан хувьд хүргэж ДНБ-ий бодит өсөлтийг 2025 онд найман хувь гэж ихээхэн өөдрөг төсөөлсөн билээ. Гэтэл үнэн хэрэгтээ 2025 он дундаа ороогүй байхад төсөвт тодотгол хийх хуулийн төслийг Засгийн газраас өргөн барьж батлуулсан. Ийн төсвийн тодотголоор зардлыг 2,3 их наяд төгрөгөөр бууруулж, төсвийн алдагдлыг 1.8 их наяд төгрөг байхаар тооцоолж нийт хасагдаж буй зардлын 1.5 их наядыг урсгал зардлаас, 600 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын зардлаас хасахаар тооцсон.

Монголын нийт өр 40.4 их наяд төгрөгт хүрч, ганцхан жилийн дотор 21 хувиар өсөв. Үүний 35.7 их наяд нь Засгийн газрын өр юм. Энэ нь мөн оны үеэс 4.8 их наяд төгрөгөөр өссөн байна. Төгрөгийн ханш ам.долларын эсрэг суларч, инфляц 11-р сарын байдлаар 8.2 хувьд хүрсэн нь өрхийн бодит орлогыг нимгэлж, дотоод эрэлтийг хумив. Азийн хөгжлийн банк, Дэлхийн

Монгол Улсын эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк


Төгрөгийн ханш ам.долларын эсрэг суларч, инфляц 11-р сарын байдлаар 8.2 хувьд хүрлээ

банк зэрэг олон улсын байгууллагууд Монголын эдийн засгийн өсөлтийг 5.7–6.3 хувь гэж төсөөлж буй ч энэ өсөлт нь чанарын бус, түүхий эдээс хэт хамааралтай хэвээр байгааг тэд сануулсаар.

2025 оны төсөв Монгол Улсад нийгмийн хамгийн эмзэг бөгөөд хамгийн чухал хоёр салбар болох боловсрол, эрүүл мэндийн салбарын асуудлыг хойш тавих боломжгүйг бодитоор харуулсан жил боллоо. Багш, эмч нарын удаа дараагийн шаардлага, ажил хаялт, олон нийтийн дэмжлэгийн үр дүнд Засгийн газар эдгээр салбарын ажилтнуудын цалинг нэмэх шийдвэр гаргасан нь нийгмийн шударга ёсны хувьд зайлшгүй алхам байв. Гэвч 2025 оны төсөвт томоохон дарамт учруулсан нь бодит үнэн. Асуудлын гол нь уг нэмэгдлийг шинэ орлогын эх үүсвэрээр бус, харин зардал танах, хөрөнгө оруулалтыг хойшлуулах, төсвийн дотоод дахин хуваарилалтаар шийдсэн явдал юм. Үүний улмаас 2025 оны төсөвт гурав дахь удаагаа тодотгол хийж, 2.3 их наяд төгрөгийн зардлыг танах шаардлага үүссэн. Өөрөөр хэлбэл, багш, эмч нарын цалин нэмэгдсэн ч энэ нь зам, дэд бүтэц, зарим хөрөнгө оруулалтын төслүүд “царцах” үнээр олдсон шийдэл байлаа.

Гэсэн ч нийгмийн өнцгөөс харвал цалин нэмэхээс өөр сонголт төрд үлдээгүй. 2025 оны инфляц найм орчим хувьд хүрч, амьжиргааны өртөг эрс өссөн нөхцөлд багш, эмч нарын бодит орлого сүүлийн жилүүдэд тогтмол буурч ирсэн. Хэрэв цалинг нэмээгүй бол хүний нөөцийн хомсдол гүнзгийрч, боловсрол, эрүүл мэндийн

Инфляцийн түвшин 2025-2026 оны таамаглал



Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк

► үйлчилгээний чанар доройтох эрсдэл бодитой байсан. Энэ утгаараа уг шийдвэр нь төсвийн бус, нийгмийн тогтвортой байдлыг хамгаалах алхам байв. Цалинг нэмэх бүрд төсөв дахин тэлж, дараа нь тодотгол хийдэг гинжин хэлхээ тасраагүй хэвээр. Багш, эмч нарын цалинг нэмэх шийдвэр зөв байсан ч энэ нь төлөвлөлтгүй, орлогын баталгаагүй төсвийн сул талыг улам тодотгосон. Хэрэв төр ирэх жилүүдэд орлогоо бодитоор өсгөх, эдийн засгаа төрөлжүүлэх бодлого хэрэгжүүлэхгүй бол нийгмийн зөв шаардлага бүр төсвийн хямралын шалтгаан болсоор байх эрсдэлтэй. Оны төгсгөлд Монголын эдийн засаг өсөлттэй мэт боловч “ядарсан” дүр зурагтай байна. Экспорт үргэлжилж байгаа ч үнэ нь унасан, төсөв батлагдсан ч тодотголтой, Засгийн газар ажиллаж байгаа ч тогтворгүй. Улс төрийн дээд түвшинд эрх мэдлийн төлөөх тэмцэл үргэлжилж, эдийн засгийн бодит реформ хойшлогдсоор.

Бид хаана алдсан бэ

Ийм эмзэг эдийн засгийн орчинд Оюутолгойн сонголт болж өнгөрсөн нь санамсаргүй давхцал биш. Харин ч 2025 оны төсвийн гүн шалтгааныг илчилсэн улс төр, эдийн засгийн толь болов. УИХ-ын Хянан шалгах түр хорооны тайлангаас харахад Оюутолгой бол Монгол Улсын эдийн засгийг “аврах” биш, харин буруу гэрээ, сул хяналтын улмаас ирээдүйн орлогыг барьцаалсан төсөл болон хувирчээ.

Таван сар гаруйн хугацаанд ажилласан түр хороо 13 удаа хуралдаж, 300 орчим гэрчийг дуудан,

35 цаг үргэлжилсэн сонсголоор 12 гол асуудлыг хөндсөн нь Оюутолгойг тойрсон асуудал ганц гэрээ, ганц заалтаар хязгаарлагдахгүй, төрийн бодлогын алдаа, хариуцлагын сул тогтолцооны үр дагавар гэдгийг тод харуулсан. Анх 53:47 харьцаатай, харилцан ашигтай байна гэж сурталчилсан гэрээ бодит байдал дээр Монголын талд 20 тэрбум ам.долларын өр үлдээж, ногдол ашиг хүртэх хугацааг тодорхойгүй болгосон нь “баялгийн хараал” бодит зүйл болохыг нотлов. Илүү ноцтой нь, үе үеийн УИХ, Засгийн газар, Төрийн аудитын байгууллагын зөвлөмжүүд бодит хэрэгжилтгүй, цаасан дээр үлдсээр иржээ. Хариуцлага хүлээх ёстой албан тушаалтнууд тодорхой бус, мэдээлэл нууцын халхавчинд оршсоор ирсэн нь олон нийтийн итгэлийг хамгийн ихээр мохоосон. “Нууцалсан баялаг эзнээ баяжуулдаггүй” гэдэг үг Оюутолгойн түүхэнд яг тохирно. Гэсэн ч энэ удаагийн сонсголын гол ач холбогдол нь өнгөрснийг буруутгахаас илүү ирээдүйг засах боломжийг нээсэнд оршино. Түр хорооны дэвшүүлсэн санал 53 хувиас доошгүй өгөөжийг гэрээгээр баталгаажуулах, санхүүжилтийн хүүг зах зээлийн жишигт нийцүүлэн бууруулах, лицензийн асуудлыг хуульд нийцүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах зэрэг нь хэрэгжиж чадвал Оюутолгой “маргааны уурхай”-гаас “өгөөжийн уурхай” болох эхлэл тавигдана. Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал, тус хорооноос санаачилсан “Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тогтоолын төслийг Улсын Их Хурал хэлэлцэн баталснаар Монгол Улсын эрх ашиг хангагдана гэдэгт итгэж байна” хэмээн онцолсон.

Эцэст нь хэлэхэд, 2025 он Монголд нэг үнэнийг дахин санууллаа. Түүхий эдийн зах зээлийн салхинд найдаж, өөдрөг тооцоонд хуургагдсан эдийн засаг удаан тэсдэггүй. Харин тогтвортой бодлого, санхүүгийн сахилга бат, төрөлжсөн эдийн засаг л савлагаатай дэлхийд улс орныг авч гарна. Үгүй бол бид жил бүр “анх удаа” төсөв баталж буй мэт маргалдсаар, маргаашийн орлогоо өнөөдрийн улстөржилтөөр барьцаалсаар байх болно. ■

Төсөв



ИХ НАЯДЫН алдагдалтай төсөв

Монгол Улсын 2026 оны төсөв улс төрийн хэрүүл шуугиан, холио солио, эмч, багш нарын жагсаал цуглааны хажуугаар амжиж батлагдсан юм.

2026 ОНЫ
ТӨСӨВТ
969.1
тэрбум
төгрөгийн
зардал
нэмэгдлээ

Багш нарын үндсэн цалинг нэмэгдүүлэхэд	518.6 тэрбум төгрөг
Эмч, эмнэлгийн байгууллагын ажиллагсдын цалинг нэмэгдүүлэхэд	193 тэрбум төгрөг
Ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэхэд	145 тэрбум төгрөг
Халамжийн тэтгэврийг нэмэгдүүлэхэд	19.5 тэрбум төгрөг
Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэтгэвэр, хүүхдийн амьжиргааг дэмжих тэтгэмжийг нэмэгдүүлэхэд	29.3 тэрбум төгрөг
Илгээлтийн эзэд тэтгэлэгт зориулж	33.0 тэрбум төгрөг

УРСГАЛ ЗАРДЛЫГ



990,169.0
сая төгрөгөөр

ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫГ




361,138.2
сая төгрөгөөр тус тус
бууруулан батлав

Төсвийн хөрөнгө оруулалт

Ирэх онд төсвийн хөрөнгө оруулалтаар 579 төслийг ₮3.3 их наядар санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Энэ дундаас, хэрэгжүүлэх төслийн тоогоор хамгийн өндөр нь боловсролын салбар бөгөөд нийт 198 төслийг 448 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөв. Харин хөрөнгө оруулалтын дүнгээр хамгийн өндөр нь зам тээврийн салбар буюу нийт 69 төсөлд 902.8 тэрбум төгрөгийг төсөвлөжээ.

Хувьчлан харвал, нийт төсвийн хөрөнгө оруулалтын 27.6 хувь нь зам тээвэрт, 13.7 хувь нь боловсролын салбарт, 9.8 хувь буюу 322.4 тэрбум төгрөг нь эрчим хүчний салбарт гэхчлэн хуваарилжээ. Харин гадаадын зээл, тусламжаар 98 төслийг 1.9 их наяд төгрөгөөр санхүүжүүлнэ. Үүнээс Азийн хөгжлийн банк хамгийн олон буюу 47 төслийг 556.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх бол удаад нь Европын сэргээн босголт, хөгжлийн банк 12 төслийг 254.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх юм байна.



ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫГ БУУРУУЛНА

/ДНБ-ий/
 2026 онд **24** хувь
 2027 онд **23** хувь
 2028 онд **22** хувь

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙГ БУУРУУЛНА

/ДНБ-ий/
 2026 онд **50** хувь
 2027 онд **45** хувь
 2028 онд **45** хувь

Монгол Улсын төсвөөс 2026 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээ /22,747,470.8 сая төгрөг/


Төсвийн ерөнхийлөн захирагч нар 2026 онд дор дурдсан төсвийг зарцуулна

Д/д	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	ДҮН /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	33,626.0
2	Монгол Улсын Их Хурлын дарга	158,919.6
3	Монгол Улсын Ерөнхий сайд	370,770.2
4	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга	5,466.1
5	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	30,341.7
6	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	291,610.7
7	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга	10,810.0
8	Улсын ерөнхий прокурор	143,898.6
9	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	23,675.1
10	Монгол Улсын Ерөнхий аудитор	55,827.5
11	Авлигатай тэмцэх газрын дарга	53,273.2
12	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	21,455.2
13	Төрийн албаны зөвлөлийн дарга	15,414.9
14	Үндэсний статистикийн хорооны дарга	29,658.7
15	Сонгуулийн ерөнхий хорооны дарга	27,381.5
16	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга	856.5
17	Шүүхийн сахилгын хорооны дарга	5,422.3
18	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	243,908.8
19	Монгол Улсын Шадар сайд	367,060.7
20	Монгол Улсын Шадар сайд	6,117.8
21	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	110,706.3
22	Гадаад харилцааны сайд	240,389.5
23	Сангийн сайд	4,567,824.7
24	Хууль зүй, дотоод хэргийн сайд	1,579,716.0
25	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	77,544.1
26	Батлан хамгаалахын сайд	790,335.4
27	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	442,066.5
28	Боловсролын сайд	4,326,616.2
29	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	4,599,159.6
30	Зам, тээврийн сайд	980,193.6
31	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	500,606.4
32	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	254,305.0
33	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	637,935.3
34	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	93,065.6
35	Эрчим хүчний сайд	455,778.9
36	Эрүүл мэндийн сайд	1,794,889.8

Тоон мэдээлэл


Инфляцын өөрчлөлт

2023 оны дундаж үнийг суурь болгов




ЭХ СУРВАЛЖ: Монголбанк

Гадаад худалдааны нийт эргэлт экспорт, импорт сая ам.доллар




ЭХ СУРВАЛЖ: Үндэсний Статистикийн Хороо

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл сая төгрөг



ЭХ СУРВАЛЖ: Үндэсний Статистикийн Хороо


Дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын бүтэц 2024 он



ЭХ СУРВАЛЖ: Үндэсний Статистикийн Хороо

Гадаадын шууд хөрөнгө оруулалт


тэрбум ам.доллар



ЭХ СУРВАЛЖ: Монголбанк

Монгол Улсын нийт гадаад өр

тэрбум ам.доллар



ЭХ СУРВАЛЖ: Монголбанк



Хөрөг

ЭДИЙН ЗАСГИЙН архитектор

“Мэдрэмжтэй байх нь мэдлэгтэй байхаас чухал” гэж Альберт Эйнштейн хэлжээ. Алив асуудалд зөв өнцгөөс харж, зөв ярьж, зөв хандаж чаддаг хүнийг мэдрэмжтэйд тооцдог. Энэ үүднээс С.Дэмбэрэл бол мэдрэмжтэй, бас мэдлэгтэй хүн. Асуудлыг харах өнцөг, биеэ авч явах байдал нь өөр. Өөрийн гэсэн өнцөг, орчныг бүрдүүлж чадсан хүн л дээ. С.Дэмбэрэл гэсэн нэрийг сонсонгуут хүмүүс тархиндаа түүний талаар бодитой төсөөллийг суулгадаг. Танхимын Дэмбэрэл, УИХ-ын гишүүн Дэмбэрэл, эдийн засагч Дэмбэрэл гээд л. Нийгэмд тэр ийм имижүүдийг бий болгожээ. Дээр нь мэдрэмжтэй дизайнер. Нийгэм, эдийн засгийн талаасаа оновчтой дизайн урладаг хүн гэж ойлгож болно. Мөн байнга л шинийг санаачилж, ярьж, ажил хэрэг болгохыг зорьж явдаг. “Өнөөдөр” сониныг үүсгэн байгуулагч агсан Ц.Балдорж “С.Дэмбэрэл бол шинэ санааны үүр уурхай” хэмээн тодорхойлсон байдаг юм.

Тэрбээр эдийн засаг гэдэг хоёр үгтэй 1978 оноос хувь заяагаа холбожээ. МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийг санхүүгийн эдийн засагчаар төгссөн цагаас өнөөдрийг хүртэл мэргэжилдээ үнэнч явж ирсэн хүмүүсийн нэг. Социализм, зах зээл, орчин үеийн нийгэм, эдийн засгийн хөгжил, алдаа оноо, сургамж, бас онцлогийн талаар тэр сайн мэдлэгтэй, мэдээлэлтэй, сайтар судалсан судлаач, эдийн засагч. Тэрбээр 1984-1997 оны хооронд Эдийн засгийн хүрээлэн, Зах зээл судлалын хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан болон захирлаар ажиллаж, эдийн засаг, зах зээлийн эрэг шураг хэрхэн эргэдгийг нарийн судалж, оюун тархиндаа шингээсэн юм.

С.Дэмбэрэлийн намтар их энгийн. Идэр насны амьдралынхаа 28 жилийг Эдийн засаг, Зах зээлийн хүрээлэнгүүд болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимтай холбожээ. 1997 оноос Танхимын даргаар ажилласнаар эдийн засгийн эс ширхэг бүрийг бизнес, хувийн хэвшилтэй холбон судалж, улс орны хөгжлийг хурдасгах, бүтээмжийг өндөрсгөх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэхийн төлөө 14

Зах зээлийн эдийн засагт шилжих цагаас МҮХАҮТ-ыг эдийн засгийн харилцаанд оруулж, хувийн хэвшлийг хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийг бий болгож, хамтран ажиллахад түүний оруулсан хувь нэмэр их юм.

жил эрчтэй ажилласан юм. Энэ ч утгаараа тэр бол практикийн эдийн засагч хүн.

Мэдлэг, мэдээлэл, туршлагыг ийм замаар, ийм хугацаанд олж авсан учраас С.Дэмбэрэл Монгол Улсын хөгжлийг зураглан харж, өргөн хүрээний асуудлыг бодит байдлаас хандаж чаддаг нэгэн. Тиймээс тэр бол бодлогын эдийн засагч. Энэ гурван тодорхойлолт нийлээд түүнийг “Эдийн засгийн архитектор” гэж нэрлэхэд хүргэж байгаа юм.

Танхимын Дэмбэрэл

Тэрбээр энэ нэрээрээ нийгэмд илүүтэй хүрсэн. Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын даргаар 1997-2014 оныг хүртэл ажиллажээ. Бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, тэднийг нэгтгэж, тэдний дуу хоолой болж 15 жил болно гэдэг бол бахархам амжилт. Бид гурван саяулхнаа. Биенийхээ амжилт, ололтоор бахархаж байвал сайхан. Улсын төсвийн ачааллыг нуруун дээрээ үүрч, бүтээн байгуулалт, хөгжлийн орчныг бүтээж яваа том, жижиг олон мянган бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжүүдийн нүүр царай болж, олон жил тогтвортой ажилласан.

С.Дэмбэрэл бизнесмэнүүд юу хүсдэг, тэдэнд ямар асуудал тулгардаг, бас юунд баярладаг, юунд гомддогийг сайн мэднэ. Асуудлыг шийдэж, гаргалгааг гаргахад түүний мэдрэмж, мэдлэг, туршлага, ур чадвар оршдог. Товчхоноор хэлэхэд, тэрбээр өнөөгийн Танхимын дизайныг урласан хүн. Зах зээлийн эдийн засагт шилжих цагаас МҮХАҮТ-ыг эдийн засгийн харилцаанд оруулж, хувийн хэвшлийг хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийг бий болгож, хамтран ажиллахад түүний оруулсан хувь нэмэр их юм. Мөн Танхимын гадаад харилцааг бэхжүүлэн хөгжүүлж, олон улс орны Танхимтай холбож, хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн гавьяа түүнийх. Үр дүнд нь МҮХАҮТ дотооддоо бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалан ажилладаг, нэр хүндтэй бизнесийн нэгдлийн хамгийн том хүчтэй төрийн бус байгууллага болж чадсан бол ▶

► гадаад талдаа мөн л Монгол Улсын Худалдаа аж үйлдвэрийн танхим гэсэн нэрийг гаргасан, байр суурийг баттай эзэлсэн байгууллага болгосон билээ.

Улстөрч Дэмбэрэл

Монгол Улсад анхлан ногоон хөгжил, ногоон үзэл баримтлал, ногоон бодлого, ногоон үзэл санааны тухай санаачлан ярьж, ажил хэрэг болгосон хүн бол С.Дэмбэрэл. Компаниудыг ногоон стратеги хэрэгжүүлэхийг, нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг, цаашлаад Монгол Улсын ирээдүй ногоон хөгжил байх ёстой хэмээн үзэж, Монгол төрийн бодлого болгож чадсан юм.

С.Дэмбэрэлийн мэдлэг, туршлага 2012-2016 оны парламентад их үүрэг гүйцэтгэсэн. Тэрбээр эдийн засаг, нийгмийн болон хуулийн төсөл дээр ажиллаж, санаа оноогоо тусгаж, идэвхтэй ажилласан. Эрүүгийн хууль, Татварын хууль гэх мэт. УИХ-аас түүнийг улс орны хөгжилтэй холбоотой том хуулийн ажлын хэсгүүдэд заавал оруулдаг, өөрөө ч орж, ажиллаж ирсэн билээ.

УИХ-ын гишүүнээр ажилласан дөрвөн жилийг түүний хувьд “Шинэ санал, санаачилгын жилүүд” гэж хэлж болно. Эдийн засаг хүндэрч хямарсан цагаас эхлэн тэрбээр гарц, гаргалгааг нь зөвхөн ярих бус бичгээр боловсруулж нотолгоо, үндэслэлийг нь гаргаж Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдтай биечлэн уулзаж тайлбарлан дэмжлэгийг нь авч хэрэгжүүлж ирсэн. Түүнийг энэ талаас нь “Шинийг санаачлагч” гэж хэлж болно. Хамгийн сүүлд түүний санаачилсан “Хүртгэмжтэй санхүүжилтийн санаачилга” хэрхэн хэрэгжсэнийг үзэхэд, Их Хурал, сонин хэвлэлд өгсөн ярилцлагууддаа тэрээр өрхийн эдийн засгийг их ярьжээ. Төр засаг үйлдвэрлэл, дэд бүтэц зэрэгт хэт анхаараад өрхийн орлого, зарлага, өр зээлд анхаарахгүй байгааг шүүмжилсэн байна.

Хүртгэмжтэй санхүүжилтийн хэлбэрүүдийг төрийн банкаар дамжуулан хэрэгжүүлж зээлийн хүүг бууруулах тухай саналаа УИХ-ын дарга, Ерөнхий сайдад тайлбарласны үр дүнд “Сайн малчин”, “Сайн оюутан”, “Сайн хашаа” төдийгүй бизнесийн зээлийн сайн орчин бүрдүүлэх зорилгоор банк бус санхүүгийн байгууллагууд, төр хоёрын хамтын ажиллагаан дээр суурилсан

**Тэрбээр
Их хурлын
танхимд
чанга дуугарч,
хэн нэгнийг
чичилж,
хэтэрхий
намчирхан,
улстөржсөн
яриа, үйлдэл
гаргаж
байгаагүй.**

“Сайн санхүүгийн орчин” санаачилгыг гаргасан байдаг.

Парламентын танхимд түүний үгийг гишүүд анхааран сонсдог байсан. С.Дэмбэрэл энэ хуулийн төслийн талаар юу ярих бол гэсэн хүлээлтийг тэр хэдийнэ бий болгочихсон. Гишүүд өрөөнд нь орж зөвлөгөө авна, уг хуулийн гол мөн чанарын талаар ярилцана, зарим нь өөрийн ойлголт, зөв, буруу эсэхийг түүнээс лавлана. С.Дэмбэрэлийн хувьд 2012-2016 онуудад маш их ажилласан, цагийг үр дүнтэй өнгөрөөсөн, эдийн засгийн архитектор, нийгмийн дизайнерыг үүргээ сайтар гүйцэтгэсэн жилүүд байв. Тэрбээр Их хурлын танхимд чанга дуугарч, хэн нэгнийг чичилж, хэтэрхий намчирхан, улстөржсөн яриа, үйлдэл гаргаж байгаагүй. Харин дуугарах ёстой үедээ намуухан өнгөөр жинтэйхэн шиг дуугарч, зөвлөдөг, үг хэлдэг, бас санаа өгчихдөг, онцлогтой гишүүн байсан.

Монгол Улсын хэмжээнд эдийн засгийн бодлогын асуудлаар суурь болон эмпирик судалгааг хийх, төрийн бодлого боловсруулагчдад бодлогын зөвлөмж өгөх зорилгоор Монголбанк дэргэдээ “Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэн”-г 2018 онд үүсгэн байгуулсан бөгөөд тус хүрээлэнгийн анхны захиралаар эдийн засагч С.Дэмбэрэл ажиллаж байв.

Самбуугийн Дэмбэрэл

Тэр жолоочийн хүү. Гэхдээ жирийн нэгэн жолоочоос Монгол Улсын Сүхбаатарын гурван удаагийн одонт, Хөдөлмөрийн баатар болтлоо хөдөлмөрлөсөн жолоочийн хүү. Социализмын үеийн ажилчин ангийн нүүр царай болж явсан тэргүүний ажилтны хүү. Монхор ногоон ЗИЛ-130 машинаараа Монголын уудам нутгаар сая километрийг туулсан, саятан жолоочийн хүү.

Хөдөлмөрлөхийн төлөө төрсөн ааваараа тэр бахархахаас аргагүй, бардамнах ч ёстой. Саятан жолооч болоход аавынх нь машин нэг ч удаа их засварт ороогүй байсан гэдэг. Тухайн үеийн ямар ч дэд бүтэцгүй, энхэл догол шороон замаар нэг ч удаагийн засварт оролгүй сая км-ийг туулна гэдэг нь улсдаа маш их эдийн засгийн хэмнэлт авчрах ач холбогдлоос гадна олон зуун жолоочийг үлгэрлэх шилдэг жишээ байсан нь ойлгомжтой. Тэр ийм л хөдөлмөрч аавын хүү. ■



since 2004
ТЭРЭЛЖ
БАЙГАЛИЙН
ЭРДЭСТ УС

ОРЧИН ҮЕИЙН
ХЭРЭГЛЭГЧИД

Эх үүсвэрийн найдвартай байдал Чанарын бодит баталгаа

Хан Хэнтийн нурууны Тэрэлжийн сав газраас, газрын гүний 120 метрийн гүнээс олборлодог “Тэрэлж Байгалийн Эрдэст Ус” нь гадаргын бохирдлоос ангид, байгалийн тогтвортой орчинд бүрэлдсэн эх үүсвэрээрээ ялгардаг.

Эрдэст усны чанарыг тодорхойлох хамгийн чухал хүчин зүйл бол эх үүсвэрийн найдвартай байдал юм.

“Ямар ус ууж байна вэ?” гэдгээс илүү
“Энэ ус хаанаас, ямар аргаар бий болсон бэ?”
гэдгийг асууж эхэлсэн.

Өнөөдөр хэрэглэгчид ундны усыг зөвхөн амт, үнэ, савлагаагаар нь сонгохоо больсон.

Тэд “энэ ус хаанаас эхтэй вэ, ямар орчинд бүрэлдсэн бэ, ямар технологиор боловсруулагдсан бэ?” гэдэг асуултыг илүү ихээр тавьж эхэлжээ.

Эх үүсвэрийн найдвартай байдал, байгаль орчинд үзүүлэх нөлөө, химийн нэмэлтгүй цэвэр технологи нь хэрэглэгчдийн сонголтын гол шалгуур болж байна.

Ингэснээр ус нь энгийн хэрэглээнээс давж, итгэл, хариуцлага, тогтвортой хэрэглээний бэлгэдэл болон хувирч байна.





БИД Усыг ямар нэг химийн бодисоор боловсруулалгүй, орчин үеийн цэвэршүүлэлт, ариутгалын технологиор дамжуулан байгалийн эрдэсийн найрлагыг өөрчлөлгүй хадгалж хэрэглэгчдэд хүргэдэг нь чанарын тогтвортой байдлын үндэс болдог.



pH 7.38 бүхий шүлтлэг, кальци, магни зэрэг хүний биед хэрэгтэй эрдсийг агуулсан бүтэц нь өдөр тутмын хэрэглээнд тохиромжтой төдийгүй эрүүл мэндэд чиглэсэн урт хугацааны сонголт байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Энэ нь “Тэрэлж” усыг зөвхөн ундны ус бус, эх үүсвэр, технологи, чанарын хяналтад суурилсан итгэл гэж тодорхойлох боломжийг олгодог.

 7575-0039

 Тэрэлж Байгалийн Эрдэст Ус



GET IT ON
Google Play

Download on the
App Store

Зочин



С.Дэмбэрэл: Өрхийн эдийн засаг сайжирч байж үндэсний **эдийн засаг** хүчирхэгжинэ

УИХ-ын гишүүн асан С.Дэмбэрэлтэй 2016 онд хийсэн ярилцлагаа хүргэж байна. Тэрбээр 2016 онд АН-аас УИХ-д нэр дэвшин өрсөлдөж байсан юм. Бидний ярилцлагын гол сэдэв өрхийн эдийн засаг. Өөдлөх улс өрхөөсөө, өрхийн эдийн засгаа анхааралдаа авч, ийш чиглэсэн дорвитой бодлого явуулснаар улсын эдийн засаг чадавхжин хүчирхэгжинэ гэсэн санааг С.Дэмбэрэл энэхүү ярилцлагадаа олонтоо илэрхийлэв.

-Их сургуулиа эдийн засагч мэргэжлээр төгсөөд “Техник импорт” компанид нябоггор ажлын гараагаа эхэлсэн байдаг. Та энэ үеэ дурсан ярьна уу?

-Одоо бидний яриад буй социализмын үеийн өрийн цалингийн тооцоог би хийдэг байлаа шүү дээ. Оросын олон мэргэжилтнийг Монголд авчирч байгууллагуудад ажиллуулна. Цалинг хянана. Би их эх оронч байж. Саяд шилжих рублийн алдааг илрүүлж, шагнуулж байсан. Ер нь би ямар ч ажлыг хийгээд эхлэнгүүт шинийг санаачилдаг. Энэ нь залхуу байдалтай минь холбоотой. Яаж энэ ажлыг хөнгөвчлөх вэ гэж бодонгуут шинэ арга олдог. Тус компанид би хоёр аргачлал санаачилга гаргасан. Нэг нь гадаадын мэргэжилтний дансыг ►

▶ шалгах нягтлан бодох бүртгэлийн аргачлал байлаа. Байнга л шинийг санаачилж явна. Энэ нь алсдаа миний тархины зуршил болчихсон. ТВ үзэж байгаад л шинэ санаа олчихно. Хүмүүстэй уулзаж, ярилцаж байгаад л шинэ санаа авчихна. Ард түмний амьдралыг сонирхож байгаад л өөр нэгийг сэднэ.

Граммын эдийн засаг гэж өнөөдөр ярьж байна. Би олон жилийн өмнө МҮХАҮТ-ын сонинны сэтгүүлчдийг зах руу явуулж, граммын эдийн засаг, хар дэвтрийн талаар сурвалжлуулж байлаа. Би ардын амьдрал их сонирхоно. Танхимд байхдаа жижиг бизнес эрхлэгчдийг түлхүү дэмжиж ажилладаг байсан. Хувийн хэвшил гэдэг өөрөө жижиг, дунд бизнес. Тэдний дуу хоолойг төрд хүргэхийн төлөө ажиллаж байлаа. Компанийн нийгмийн хариуцлага, органик бүтээгдэхүүн гээд л шинэ санаа сэдэх зуршлын минь үр дагаврууд.

Нэг удаа орос сонинноос оросууд ТОП-100 аж ахуйн нэгжээ шалгаруулж урамшуулдаг тухай олж уншаад эндээс санаа авч, Монголын анхны ТОП-100 аж ахуй нэгжийг шалгаруулах арга хэмжээг хийж байлаа. Энэ арга хэмжээ өнөөдөр тогтмолжоод 24 жил болж байна. Цаг хугацааны түрүүнд алхаж, шинийг санаачилж, сэдэх, амьдралд нэвтрүүлэх нь миний дадал, зуршил бас зан чанарын минь онцлог болжээ. Тиймээс би Танхимынхаа ажилтнуудад “Хүн бүхэн өглөө сэрэнгүүт шинэ санаа бодох хэрэгтэй.Тархиа ажиллуулж, шинийг санаачилж, идэвхтэй амьдар” гэж байнга хэлдэг байсан.

-Та сая АН-д элсэхдээ АН-ын өнөөгийн эдийн засгийн үзэл баримтлалыг 25 жилийн өмнө бичиж өгч байсан гэдгээ хэлж, тэр илтгэлийн эх хувилбарыг АН-ын дарга З.Энхболдод гардуулж өгсөн. Монгол Улсын зах зээлийн эдийн засгийн одоогийн бодлогын бүх үндэс суурийг таныг тавьжээ гэж ойлгож байна.

-Түүх л юм даа. Ардын намын модон тамгыг хэн сийлсэн юм бэ гэдэг шиг АН-ын модон тамгыг би сийлсэн байна шүү дээ. Тухайн үед би Зах зээлийн хүрээлэнгийн захирлаар ажиллаж байсан юм. МҮДН-ын 1990 оны тавдугаар сарын 13-ны хурал дээрх эдийн засгийн илтгэлийг нь би бичиж, өөрөө уншиж байлаа. Циркт болсон юм. Заал дүүрэн дээлтэй хүмүүс, ганцхан костюмтай хүн нь би. Илтгэлээ дээшээ ч харахгүй уншаар л дууссан. 1991 оны нэгдүгээр сард болсон МоАН-ын анхны хурлын “Монгол Улсын эдийн

засгийн үзэл баримтлал” илтгэлийг би бичиж өгч байсан. МоАН-ын эдийн засгийн анхны концепц нь зах зээлийг биш, социализмыг сайжруулахад чиглэсэн байсан. Харин би тэр илтгэлээрээ зах зээлийн эдийн засгийн концепцыг гаргаж өгсөн юм. Тэр илтгэлээ дөрвөн шил Болор архиар бартердаж билээ.

-Тийм үү?

-Үр дүнд нь АН өнөөгийн мөрдөж буй зах зээлийн концепцын эхлэлтэй болсон. 25 жилийн өмнө би одоогийн яриад буй асуудлуудыг бичиж байж. Хувьчлал, макро эдийн засаг ингэж явах ёстой гээд л. “Монголын эдийн засгийн өнөөгийн байдал 1991 он” гэсэн илтгэл миний вэб сайтад байгаа. Хүмүүс сонирхвол уншиж болно шүү. Маш сонирхолтой.

-Та намын гишүүн нь байсан юм уу?

-Намын гишүүн биш ээ. Миний хувьд МҮДН-ын үүсгэн байгуулагч, Шинэ дэвшилт холбооны үүсгэн байгуулагчдын нэг. Ардчилсан холбооныхонтой ойр дотно явж ирсэн хүн. Жагсагчид 1990 онд Төв талбайг гороолоод явж байхад дунд нь явж л байсан. Тараад шөнийн 02 цагт гэртээ очиж байлаа. Ардчиллыг дэмжиж, жагсаалд оролцоноосоо болж ажлаасаа халагдсан. Намын гишүүн бус явсаар 2012 онд л Иргэний зориг, Ногоон намын гишүүн болсон.

-Та УИХ-д дөрвөн жил төрийг төлөөлж суулаа.Танд юу бодогдож байна вэ?

-УИХ-ын гишүүн хүн юу ч хийхгүй байж болох юм байна, эсвэл ихийг хийж болох юм байна гэж л бодогдсон. Би хоёр дахь замыг нь сонгосон. Маш их ажилласан. Эдийн засаг, хүний эрх, улс төр, нийгэм гэсэн дөрвөн үндсэн чиглэлд голлон анхаарч ажиллалаа. Тайлангаа бэлтгэсэн чинь 500 гаруй хуудас болж байна. Тийм зузаан юмыг хүн уншихгүй л дээ. Товчлоод 50-аад хуудастай тайлан гаргасан. Хийсэн ажлуудаа онлайнаар нээлттэй байршуулсан байгаа. Миний санаачилсан, хамтран оролцсон, ажлын хэсэгт нь орж ажилласан олон хууль бий.

-Та УИХ-д дахин нэр дэвшлээ. Яагаад дахин нэр дэвших болов?

-Энгийн л дээ. Нэгдүгээрт, өнгөрсөн дөрвөн жилийн ажлаа үргэлжлүүлж, үнэлүүлэе. Хоёрдугаарт, Монгол Улсын эдийн засгийн тогтолцоог өрх гэр рүү, хүн рүү чиглүүлэх гол зорилго байна.

Дэлхий даяар эдийн засгийн бүх сурах бичигт өрх гэр, Засгийн газар, пүүс буюу банк гэсэн ▶

► үндсэн гурван оролцогч байдаг шүү дээ. Монголд ч адилхан. Гэхдээ нарийн сайн ажиглах юм бол өрх гэрийг бүх нийгмийн тооцоо, бүртгэлд оруулсан хэрнээ эдийн засгийн институцын хувьд оруулж тооцохгүй байна. Хэдийгээр статистикийн мэдээлэл дээрээс өрхийн орлого зарлага гэх мэтчилэн мэдээлэл олж үзэж болох ч шийдвэр гаргах, хууль батлах процессыг харахаар өрхийн эдийн засаг гэсэн ойлголт манайд суугаагүй байна. Өөрөөр хэлбэл, компанийн эдийн засаг гэхээр хувийн хэвшил гээд ойлгочихно, Засгийн газрын эдийн засаг гэвэл төсвөө ярина.

Харин өрхийн эдийн засгийг ерөнхийдөө зөнд нь орхисон байдалтай. ДНБ-ий зардлын зонхилох хувийг бүрдүүлдэг өрхийн эдийн засгийн макро түвшний бодлогыг орхигдуулсан. Үүнээс болоод 2012 оноос хойш бондын болон төсвөөр дамжсан Засгийн газрын хөрөнгө оруулалтын график өсөлттэй явж байхад эдийн засгийн бодит үзүүлэлт буюу өрхийн орлогын график доошилж байв. 2014 оны эхний улирлаас хойших графикайг харахад өрхийн орлогын өсөлт доошилсоор байгаад 2016 оны эхний улиралд хасах руу орчихсон. Энэ бол гаж үзэгдэл. Зам бариад, шугам тавиад, хөрөнгө оруулаад байгаа хэрнээ ард иргэдийнх нь орлого муудаад байдаг. Тэгэхээр энэ чинь эдийн засаг мөн юм уу?

“Өрхийн эдийн засгийг хөгжүүлэх тухай” хууль боловсруулж дууссан

-Тэгэхээр одоо яах вэ, тулгын гурван чулууны нэг хэсэг, өрхийн эдийн засгийг бид бараг ярьдаггүй шүү дээ?

-Энэ асуудлыг уг сууриар нь судлахаар түрүүний хэлдэг жирийн эдийн засгийн сурах бичигт бичээстэй байдаг тулгын гурван чулууны нэгийг орхигдуулсан. Аль ч нам, ямар ч мундаг эдийн засагч хөгжлийн тухай ярьсаар энэ л гаргалгаан дээр очно. Дэлхий даяар ДНБ-ийг орлогын, үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын гэсэн гурван аргаар тооцдог. Манайх ч адилхан. Үйлдвэрлэлийн арга нь буюу аж үйлдвэр, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбаруудад орлого хэрхэн хуваарилагдав гэдгийг тооцдог. Эцсийн ашиглалтын арга нь тухайн ДНБ-ийг яаж зарцуулав гэдгээр нь тооцдог. Энэ аргын өрхийн эцсийн хэрэглээний зардал гэдгийг анхаарахгүй, эдийн засгийн макро түвшний үгсийн санд нь

орүүлж чадаагүй байна. Ганц Монголбанк л судалгаандаа ашигладаг. Гуравдугаар арга болох орлогын арга буюу үйлдвэрлэгдсэн дотоодын нийт бүтээгдэхүүн юунд очив гэдэг асуудал. Үндсэндээ цалингийн тухай гэж ойлгож болно.

ДНБ-ийг тооцдог гурван нүд байсаар атал зөвхөн нэгийг нь ашиглаад байна. Ингээд өрхийг эдийн засгийн орчлоос гаргачихсан учраас тэд хаана, хэнээс, ямар зээл авч байна, яаж орлого олж юунд зарцуулж байна, хэдийг хуримтлуулж байна, ямар хэлбэрээр хадгалж байна гэдгийг нэгтгэсэн макро статистик байхгүй. Хэдийгээр Улсын бүртгэл, Статистикийн газраас өрхийн орлого зарлагын статистикийг гаргадаг ч түүнийг макро хэрэглээнд нэвтрүүлээгүйн улмаас жил бүрийн төсвийн бодлого, мөнгөний бодлогын үндсэн чиглэл өрхийн амьдралаас хөндий байдаг. Дээгүүрээ нэг их тоо яриад байдаг атал өрх нь тэнд өөрөө өөрийгөө л болгохоос аргагүй байдалтай.

Бидний хамгийн түрүүнд санаа зовох асуудал бол өрхийн орлого, өрхийн санхүүгийн дарамт. Тэгээд өрхийн орлогыг нэмэгдүүлэх санхүүгийн хүртээмжтэй ямар эх үүсвэрүүд байна гэсэн эсдвүүдийг хөндөж ярих цаг болоод байна. Тийм учраас “Өөдлөх улс өрхөөсөө” гэж би хэлээд

Хувийн хэвшил гэдэг өөрөө жижиг, дунд бизнес. Тэдний дуу хоолойг төрд хүргэхийн төлөө ажиллаж байлаа.

яриад байгаа юм. Энэ талаас нь бодож цаашид Их хурал дээр ажиллана. Одоо би сонгууль болох гэж байхад “Өрхийн эдийн засгийг хөгжүүлэх тухай хууль” боловсруулаад сууж байна.

Сая ярьсан онолын болон бодлогын үндэслэлүүдээ гаргаж тавиад, ер нь цаашид Монгол Улсын шийдвэр гаргах процесст өрхийн эдийн засгийг яаж авч хэлэлцэж байх юм гэдэг үндсэн суурийг тавих гэж байна.

Энэ бол социалист эдийн засгийн тогтолцооноос үүдэлтэй Монголын 26 жилийн түүхэнд эдийн засагт үүссэн гажиг. Уг нь социализмын үед ч өрхийн орлого, зарлагыг тооцдог, ард түмний амьжиргааны түвшний дээшлүүлье гэж байнга хэлдэг байсан. Гэхдээ эдийн засгийг уул уурхай, хөдөө аж ахуй, аж үйлдвэр гэх мэтчилэн салбараар нь ангилж хардаг өнцөг өөрчлөгдөөгүй. Түрүүн хэлсэнчлэн үндэсний тооцоог хийдэг гурван өөр арга байна шүү дээ. Салбараас нь гадна институцээр нь ангилж хардаг. Тэр бүрийн орлого, зарлага, ►



► хуримтлал, хэрэглээ гээд нарийн үзүүлэлтүүд бэлэн байсаар атал хэрэглэхгүй байгаа юм. Хэлэх гээд байгаа гол санаа маань эхлээд өрхийн эдийн засаг нь сайжирч байж үндэсний эдийн засаг хүчирхэгжинэ. Ингээд дэлгэрүүлээд яривал их зүйл ярьж болно.

-Тэгвэл өрхийн эдийн засгийг яаж сайжруулах вэ?

-Хамгийн түрүүнд тулгын гурван чулуугаа зөв тавьж, дутуу орхисон “өрх” гэдэг нэг үндсэн оролцогчоо төр бодлогодоо оруулж ирэх хэрэгтэй. Уг нь эдийн засагт үүргээ гүйцэтгээд байгаа ч бодлогын гадуур үлдчихсэн. Төрийн баримт бичгүүдэд өрхийн бодит орлогыг дээшлүүлэхэд чиглэсэн ажил хийнэ гэсэн өгүүлбэр их цөөхөн. Дандаа л экспортыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих гэсэн юм ярьдаг.

Өрхийн эдийн засгийг сайжруулахын тулд санхүүжилтийн орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Үүнд дарамт болдог гурван зүйл л бий. Инфляц, ажилгүйдэл, зээлийн хүү. Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш дандаа хүүгийн өндөр дарамт дор явж ирлээ. Энэ нь инфляц бий болох гээд бусад асуудлын шалтгаан болж байсан. Тийм болохоор би хүртээмжтэй санхүүжилт гэж ярихаар хүний чихэнд буухгүй байна. Сайн малчин, сайн оюутны зээл гэх мэтчилэнгээр яам тамгын газар, банк бус санхүүгийн байгууллагуудыг оролцуулаад, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Сангийн сайдтай уулзаад зээлийн хүүг бууруулья, хүртээмжтэй санхүүжилт бий болгоё гэж яриад яваа минь ийм учиртай. Үүнд ББСБ-ыг оролцуулж байгаа

нь ч учиртай. Өнөөдөр өрхийн бизнес эрхэлдэг 60 мянган хүнд 150 гаруй ББСБ санхүүгийн үйлчилгээ үзүүлж байна. Тэдэнд бизнесээ хийхэд нь бага хүүтэй зээл хэрэгтэй байна. Гэхдээ тэглээ гээд шууд та нар хүүгээ бууруул гэж ББСБ-уудад хэлж чадахгүй.

Тиймээс хөшүүрэг хэрэгтэй. Төр бага хүүтэй зээл олгох боломжийг эрэлхийлэх ёстой. Тухайлбал, ББСБ-уудад бага хүүтэй зээл олгож, тэд нь өрхийн бизнес эрхлэгчдэд буюу эцсийн хэрэглэгчдэд боломжийн нөхцөлтэйгөөр дамжуулан зээлддэг болох. Энэ эхлэлийг тавьж өөрчлөлтийг явуулах хэрэгтэй. Гэх мэтчилэн ажилгүйдэл, ядуурлыг багасгах хөтөлбөр боловсруулаад ажиллах ёстой. Төр байгаа л юм бол өрхийн эдийн засгийн асуудлуудыг мартаж учиргүй. Яагаад гэвэл эцсийн ашиглалтаар тооцсон ДНБ-ий 60 хувийг өрхийн хэрэглээ эзэлж байгаа.

Өрх орлоготой байж зардал гаргана. Тэгэхээр орлогыг нэмэгдүүлэх санхүүгийн эх сурвалжуудыг бий болгох хэрэгтэй. Санхүүгийн хөшүүргүүдийг зөв ашиглаж байж л бодлого ажил хэрэг болно. Ард түмний аж амьдралыг дээшлүүлнэ гэж ярьчихаад ямар нэгэн санхүүгийн хөшүүрэггүй бол тэр ажил явахгүй. Тухайлбал, малчдыг ноосоо эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд тушааж бай гэсэн тушаал гарлаа гэж бодъё. Зүгээр хоосон тушаал бол хэрэгжихгүй. Харин ноосны урамшуулалд хоршооны гишүүн малчин хамрагдана гэснийг хасчихад л малчид өөрсдөө ноосоо тушаагаад явчих жишээтэй.

Нэг гол санхүүгийн хөшүүрэг нь моргэйж. Өнөөдрийн нөхцөл нь залуу гэр бүлүүдэд хүнд байна шүү дээ. Зээлдэгчдийн дийлэнх хувийг 44 хүртэлх насныхан бүрдүүлж байна. Тэд 1000 төгрөгийн орлоготой байлаа гэхэд 400 төгрөгийг нь моргэйжид төлж, үлдсэнээр амьдарч байгаа. Тэгэхээр өрхийн хэрэглээ хумигдаж, зах зээл дээрх оролцоо багасна. Тиймээс моргэйжээ чөлөөтэй түлхье. Зөвхөн хүүг нь таван хувь болгож бууруулах биш илүү уян хатан болгох хэрэгтэй. Тухайлбал, хоёр хүүхэдтэй залуу гэр бүл, дөрвөн хүүхэдтэй залуу гэр бүлийн моргэйж ялгаатай байх гэх мэт. Эсвэл эхний гурван жил үндсэн төлбөрөөс чөлөөлөх зэрэг олон улсын туршлагауд бий. Үүнийг зайлшгүй хууль эрх зүйн орчинд өөрчлөлт оруулж байж л хийнэ.

Өрхүүдийн орлого нэмэгдэж байж л моргэйж ►

► том байх боломжтой. Нэг сая хоёр зуун мянгаас доош орлоготой өрхийн орлогыг нэмэгдүүлж, моргэйжид хамруулах гарцыг олох зэрэг эдийн засгийн бодитой асуудлууд өрхийн түвшинд байна. Гэтэл моргэйж нь өрхийн эдийн засагтайгаа уялдаагүйгээр явж ирсэн. Өнөөдөр 80 мянган өрх хамрагдсан ч цаашид орлого нь буураад байвал моргэйжид хамрагдах өрх олдохооргүй байна.

-Үүнийг хуульчлах ямар шаардлага байгаа вэ?

-Энэ бүхэн ямар ч системгүй явж ирлээ. Одоо улсын хууль эрх зүйн орчинд нь оруулж өгье. Өнөөдөр өрхийн эдийн засгийг хөгжүүлэх тухай хууль Монгол Улсад байхгүй. Би бичээд боловсруулж дуусгаад өргөн барина. Энэ бол УИХ-ын гишүүнийхээ хувьд миний хийж байгаа ажил. Өнөөдөр өрхийн эдийн засгийн мэдээллийг бүрэн цогцоор нь харах боломж ч алга. Өрхийн эдийн засгийн бүрэн дүр зургийг гаргахын тулд Улсын бүртгэл, Статистикийн газрын, Монголбанкны, Сангийн яамны гэх мэт тайлан мэдээнүүдийг бүгдийг ашиглаж үзүүлэлтүүдийг хооронд нь уялдуулах шаардлагатай.

Өрхийн эзэмшлийн орлого дээр ярья л даа. Бүх татвараа төлчихөөд үлдэж байгаа мөнгө нь нэг өрхөд болон нийт үндэстний хэмжээнд хэд байгаа вэ гэх статистик байгаа боловч хэрэглэдэг хүн байхгүй. Статистик талаасаа ч сайжруулах шаардлагатай. Уг нь үүнийг бодлого боловсруулагч болгон мэдэж байх ёстой. Жил болгон макро эдийн засгийн талаар баримтлах үндсэн чиглэлийг Засгийн газар танилцуулдаг. Тэгэхдээ Засгийн газрын эдийн засаг ийм байна, өрхийн эдийн засаг ийм байна гээд тоонуудаа дурддаг болох юм бол өрхийн эдийн засаг систем рүүгээ орж, төсвийн болон мөнгөний бодлого шийдвэрт харгалздаг болох юм.

Үүнийгээ мэдэхгүйгээр бодлого тодорхойлдог 76 гишүүн ард түмэндээ хайртай гэж хоосон яриад байгаа хэрэг. Ард түмний амьдрал муудлаа, граммын эдийн засагтай боллоо гэж ярих нь чухал биш. Зөв системтэй тооцоо гаргаж мэргэжлийн нүдээр харж баримттай, тооцоотой ярьж, Засгийн газарт маш тодорхой үүрэг даалгавар өгдөг болох хэрэгтэй. Ингэж хандлагаа өөрчилж байж 2030 онд ядуурлыг эцэслэх зорилгодоо хүрнэ.

Өнөөдөр ядуурал 20 хувьтай байна. Монголын нийгмийн давхраажилтын пирамидыг харахаар нийт өрхийн 60 хувь нь 301-500 мянган төгрөгийн орлоготой байгаа. Уучлаарай, энэ чинь худлаа.

Яагаад гэхээр арга зүйн талаасаа буруу. 2007 оноос хойш хийсэн судалгаанд үндэслэж хийсэн миний тооцоогоор 30-35 хувь юм. Яагаад ийм буруу тоо гараад байна гэхээр 2010 оны зэрэгцүүлсэн үнээр тооцсон болохоор ийм өндөр хувь гарч ирсэн. Зэрэгцүүлсэн үнийг гаргаж болдог л доо, гэхдээ арга зүйн талаасаа алдаа бий.

Өөрөөр хэлбэл, хүн амын бодит орлогыг тооцохдоо бүлэг тус бүрээр нь тухайн жилийн инфляцын түвшингээр засварлах ёстой. Зургаан жилийн өмнөх инфляцыг засварласан байдлаар биш. Тэгэхээр пирамид ямар болж байна гэхээр ядуу болон эмзэг бүлэг нь 30-35 хувь. Монголд шинэ анги бий болгож байгаа дунд анги биш мөртлөө дундаас доош анги нь 40-45 хувь. Үүний дээр 15-20 хувийг дунд анги бүрдүүлж байна. Нэг хэсэг дунд анги 60 хувь байна гэж тооцоод 2030 онд 80 болгоно гэдэг зорилт тавьж байгаа. Гэтэл дунд анги гэдэг ойлголтоо ч тодорхойлоогүй байна.

Цаашлаад дунд ангийн талаар судалгаа байх ёстой. МУИС-ийн Хүн ам зүйн хүрээлэн нэг удаа судалгаа хийсэн нь бий. Гадаадын зарим судлаачид хийсэн байдаг. Гэхдээ Монголд социологийн судалгааны мэргэжлийн байгууллагууд үүнийг хийх ёстой. Cvvvv нь статистикийн олон жилийн

2014 оны эхний улирлаас хойших графикийг харахад өрхийн орлогын өсөлт доошилсоор байгаад 2016 оны эхний улиралд хасах руу орчихсон. Энэ бол гаж үзэгдэл.

судалгаа, ХАХНХЯ-ны хүн амын амьжиргааны түвшнийг 20 ангилсан судалгаа бий. Бас хүмүүс өөрсдийгөө аль ангид хамааруулж байна гэдгийг судалдаг аргачлал байдаг. Орлого талаас нь албан бус сектор өрхийн эдийн засгийг судалсан байдлаас үзэхэд 40-45 хувь нь дундаас доош давхаргад орж байна.

Тэгэхээр ядуу, эмзэг хэсгийг 15 жилийн дараа тэг болгох зорилтод хүрэх боломжтой. Дэлхий нийтээрээ ийм зорилго тавьсан байгаа. Одоо чинээлэг, дундаж давхаргыг яаж бий болгох вэ гэж улс төрийн нам болгон ярьж байна. Түүний тулд давхарга хоорондоо шилждэг сувгийг нээж өгөх ёстой. Тэр сувгийг нээх нэг гол хэрэгсэл нь миний хэлдэг хүртээмжтэй санхүүжилт, зээлийн тааламжтай орчин юм.

Монголын санхүүгийн салбарын 95 хувийг банк эзэлж байна. Гэхдээ үлдсэн таван хувь буюу даатгал, банк бус санхүүгийн байгууллагууд дээр очиж байгаа бизнес эрхлэгчид нь банкуудын ►


► үйлчлүүлэгчдээс ч их. Өөрөөр хэлбэл, банканд сайн зээлийн түүхгүй, нэг их очдоггүй, очсон ч зээл олддоггүй, төрийн элдэв хөтөлбөрт хамрагдаж чаддаггүй хэсгийнхэн ББСБ-д хандаж байна. Иргэдийн хувьд бол ломбардаас. Тиймээс тэднийг төрийн анхааралд авч хүртээмжтэй санхүүжилтийн хэлбэрт оруулах нь эцсийн зорилт.

Эхний алхмаа ломбард дээр хийснээр хариуцсан эзэнтэй болгож Санхүүгийн зохицуулах хороо хүртээмжтэй санхүүжилт болгох талаас нь хариуцдаг. Ингэснээр ломбардууд мөнгө хүүлэгч биш, зээлдэгч нь хүүндээ дарамтлуулдаггүй зэрэг хөгжих боломжийг олгоно. ББСБ-уудыг мөн Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо хооронд нь холбож сайн санхүүгийн орчин бий болгох санаачилга гаргаад явж байна. 60 мянган өрхийн бизнес эрхлэгч хүртээмжтэй санхүүжилт аваад ирэхээр маш олон өрхийн амьдралд хэрэг болох юм.

-Та хэр үглээ хүн бэ?

-“Үглэх” үү. Миний насаараа үглэж ирсэн юм бол бизнес, хувийн салбар юм даа. Би өөрийгөө бизнесийн бие хамгаалагч гэж хэлнэ. Миний нэг ном тийм нэртэй. Business advocacy гэсэн тусгай томъёолол байдаг. М.Энхсайхан Ерөнхий сайдын үед би анх удаа “бизнесийн орчин” гэдэг үгийг гаргаж байлаа. Түүнээс хойш бизнесийн өмгөөлөл хийж ирсэн. Өөрөөр хэлбэл, төрийг хажуунаас нь засаж, үглэж, алдааг нь хэлж өгдөг гэсэн үг. Жишээ нь сая guillotine буюу тас цавчих маягийн юм хийж үзлээ. УИХ-ын гишүүн байж Засгийн газрын багт нь орж, өөрөө ахлаад яамдын тусгай зөвшөөрөл, лицензийн тоог багасгах гэж өнгөрсөн дөрвөн ажиллалаа.

Ер нь хүн засаглал руу орохоор сонин аппетит хөдөлдөг юм байна. Өөртөө эрх мэдлийг хадгалах, ингэснээр хүчийг гаргаа атгаж байх хүслээ гүйцэлдүүлэх. Засгийн газраар дамжуулаад зах зээлд маш их зохицуулалт хийж эхэлсэн. Миний хувьд үүнийг өнгөрсөн арван жилд ажиглаад, зохицуулалтын реформ гэж үг, ажил санаачилсан юм. Хамгийн сүүлд л гэхэд миний олон жил хэлж, бичиж ирсэн ухаалаг төрийг Ерөнхийлөгч хийж эхэлсэн. Энэ мэтээр засагт ойлгуулахын тулд үглээд, мэдэгдэл гаргаад, УИХ дээр ороод ирэнгүүт нь мөнгөний бодлого, бизнесийн орчин, төсвийг нь шүүмжлээд засаж залруулах боломж гардаг. УИХ-ын гишүүнд чинь асар их материал ирдэг юм байна. Уншихын эцэсгүй. Тодорхой чухал зүйлээ л сорчилж уншихгүй бол маш хэцүү.



Миний насаараа үглэж ирсэн юм бол бизнес, хувийн салбар юм даа. Би өөрийгөө бизнесийн бие хамгаалагч, body-guard гэж хэлнэ, миний нэг ном тийм гарчигтай. Business advocacy гэсэн тусгай томъёолол байдаг. М.Энхсайхан Ерөнхий сайдын үед би анх удаа “бизнесийн орчин” гэдэг үгийг гаргаж байлаа. Түүнээс хойш бизнесийн өмгөөлөл хийж ирсэн.

Гэхдээ дотор нь ороод ажиллаад ирэнгүүт давуу талтай, Засгийн газар, Монголбанк, Сангийн яамны алдааг хараад харилцаад нөлөөлөх боломжтой болж байгаа юм.

-Таныг хүмүүс Иргэний зориг намаас урваж, Ардчилсан намд орчихлоо гэж байна. Та тайлбар хийх үү?

-Албаар “урваад” гэж хэлээд байгаа юм. Уг нь бол дайсанд л урвадаг биз дээ. Иргэний зориг нам, Ардчилсан нам нэг үндэстэй. Тэр үндэс нь бол чөлөөт зах зээл, Засгийн газрын хязгаарлагдмал оролцоо, эдийн засгийн эрх чөлөө. Эдгээрт суурилсан нэг үзэл баримтлалтай намууд. Хоёр намын харилцан тохиролцсоны дагуу, хуулийн шаардлагаар Ардчилсан намд орсон. Ардчилсан намд орохдоо “Би шинэ хүн биш, 1991 онд үзэл номлолыг нь бичиж өгсөн хүн орж ирж байна” гэж хэлсэн. Тийм учраас архивын баримтыг намын даргад нь гардуулж өгсөн. 1991 онд Монголын Ардчилсан нам социализмыг сайжруулах зорилготой байхад нь С.Дэмбэрэл гэдэг хүн илтгэлийг нь бичиж өгснөөр 1991 оны нэгдүгээр сард зах зээлийн эдийн засгийн хөтөлбөртэй болсон.

Нөгөө талаас хуулийн шаардлагын дагуу ►

► зайлшгүй Ардчилсан намд элсэж байж нэр дэвших ёстой. Би одоохондоо АН-ын үүдээр нь ороод ирчихлээ. Тасалгаануудаар нь яваагүй байна. Олон л тасалгаатай юм шиг байна.

Яагаад энэ намд орсон гэхээр нэгдүгээрт, үзэл баримтлалаа дагасан. Хоёрдугаарт, алдаатай оноотой зүйлүүдийг нь би мэднэ. Өнгөрсөн дөрвөн жилд би МАН-аас илүү АН-ыг хамгийн их шүүмжилсэн. Тэгэхдээ үргэлж алдааг нь хэлж өгдөг. АН алдаатай, бас ололттой нам. Өнөөдөр их ярьж байх шиг байна. Уг нь алдаагаа их ярих ёстой. Энэ алдаагаа ингэж засна гэж ард түмэндээ хэлбэл хүмүүсийн итгэл бөхөөгүй байгаа.

Өнгөрсөн дөрвөн жилд дотооддоо их зөрчилдсөн, ерөнхийдөө рейтинг нь их муу байгаа намд би засах гэж орж байгаа. Бүх юмыг засч болдог. Хамгийн гол нь алдаагаа ойлгоод, гаргалгаа гаргадаг чадвар байх ёстой. Тийм чадвартай нам гэж итгэсэн. Түүнд нь би хувь нэмрээ оруулъя. Өнгөрсөн дөрвөн жилд миний үгийг сонсдог байсан, тодорхой орчин үүсгэсэн учир АН-д орж ирлээ. Дээр ярьсан асуудлуудаа би АН-аар хийлгэнэ. Ямар тохиолдолд УИХ-аар Монголын эдийн засгийг хөгжүүлэх тухай л ярина. Энэ үед л өрхийн эдийн засгийг бодитойгоор, телевизийн микрофон харалгүйгээр арын фронтод сууж бичиж өгдөг зангаараа ажиллана.

Сайн зээлийн орчныг бий болгохоор хөөцөлдөж байна. Сайн цалин, тэтгэврийн орчин хөтөлбөр мөдхөн зарлагдана. Энэ бүхэн нийгмийн цөхөрсөн сэтгэл, алдагдсан итгэлийг сэргээх зорилготой. Нийгмийн мөн чанар нь ийм. Итгэсэн нам нь муу юм хийгээд байвал уурладаг, сайн юм хийгээд алдаагаа засаад байвал эргээд сэргэдэг. Энэ талаас нь ажиллана.

Ер нь надад сонголт байсан. Өөрөөр хэлбэл, би сонгуульд дахиж үзэхгүйгээр, маш гоё ярилцлагууд өгчихөөд, янзын сайхан шүүмж бичээд соён гэгээрүүлэх ажил хийгээд, цаг гарвал зээ хүүтэйгээ тоглоод сайхан байж болно. Гэхдээ хүнд өөрийн гэсэн натур байдаг. Би бол төрд орж ирсэн арай өөр бодолтой хүн. Яагаад гэвэл нийгмийн нэг хэсгийнх нь зовлон жаргалыг өөрийн биеэр мэдэрч, зөөж авчирсан төлөөлөл.

Манай төр урлаг талаас нь харвал болоогүй байна. Өө ихтэй байна. Тэр өөг арилгахын тулд би сонголт хийж байгаа. Дахин давтахад УИХ-д юу ч хийхгүй байж болно, эсвэл маш их зүйлийг хийж болно. Тийм учраас энэ сонголт таалагдаж байна. Анх УИХ-д ороход бүгд ижилхэн байсан, сүүлдээ

тодорхой сэдвүүдээр намайг сонсдог болсон. Тэр нь миний бахархлыг төрүүлж байна. Тиймээс тэр хүмүүстэй дахиад хамт байж, олон зүйлийг хиймээр байна. Ерөөсөө л энэ.

Аавынхаа суран бүсний амтыг олонтоо мэдэрсэн дээ

-Таныг хүмүүс танина, Танхимын даргаар олон жил ажилласан гэдгээр чинь илүүтэй мэднэ. Хүүхэд насны дурсамжаасаа хуваалцана уу?

-Миний хүүхэд нас нийслэлд л өнгөрсөн дөө. Улаанбаатар хотод төрж өссөн хүүхэд. Гэр хороолол, 120 мянгат, микр буюу 12 дугаар хороолол гээд манайх олон газар нүүсэн. Сахилгагүй талдаа, гадуур их дэмий тэнэдэг хүүхэд байлаа. Өвлийн хүйтэнд гэдсээ гаргачихаад л явдаг байсан гэдэг. Сургуульдаа бол явна. Хичээлээсээ ирээд хоол идчихээд л гараад явна даа. Дэмий тэнэж, тоглож яваад оройхон л гэртээ орно. Би их хоолонцор. 5-6 нэмүүлнэ шүү

дээ. Гэхдээ гэртээ хичнээн оройтсон ч гэрийн даалгавраа заавал хийж унтана. Манай гэрийн дүрэм ийм юм л даа.

-Таны аав бол Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Самбуу гуай. Улсдаа бол хамгийн шилдэг ажилтан байжээ.

-Аав маань хөдөө тээвэрт явж явж ирээд гэртээ хамгийн удлаа гэхэд долоо хоноод л эргээд явна. Үр хүүхэд бидэндээ бол хамгийн мундаг аав байсан. Аавыг хөдөөнөөс ирэхэд ээж хөвгүүд нь хэр хүмүүжилтэй байсан талаар аавд тайлагнана даа. Чихэнд сонсголонгүй асуудлууд сонсохоороо аав биднийг жагсаан зогсоож байгаад суран бүсний амт үзүүлнэ. Миний хувьд ийм амтыг олонтоо мэдэрсэн хүү нь. Гэхдээ суран бүсний муу зүйл гэж байдаггүй юм шүү. Мөн аав минь хөдөөнөөс ирэхдээ мөсөн чихэр бөөндөж авч ирээд л бидэнд өгдөг сөн. Аав дуу цөөнтэй, ээж үглээ. Хааяахан аав бидэнд “Шарай голын гурван хаан” үлгэрийг ярьж өгнө, жүжиглэнэ, үлгэрч өвгөний дүрд хувирна. Аав Ардын жүжигчин Ц.Гомбосүрэн гуайтай найз байсан болохоор жүжиглэх авьяастай. Бас их ном уншдаг хүн байж. Түүгээрээ биднийг үлгэрлэж, бүгдийг номонд дуртай болгож өсгөсөн дөө. ►

Дахин давтахад УИХ-д юу ч хийхгүй байж болно

► **-Эрэгтэй хүүхдүүд багаасаа л машин тэргэнд сонирхолтой байдаг. Та нар харин аавыгаа хэр дагадаг, машинд дуртай хүүхдүүд байсан бол?**

-Аав алсыг харсан бодолтой хүн байсан. Биднийг машин тэргэнээсээ аль болох хол байлгадаг, машинд дургүй болгох талд л зогсдог хүн байж. Хааяахан л тээвэрт авч явна. Үргэлж биш. Аавыгаа дагаж, машиных нь кабинд суугаад л хөдөөг зорих сайхан шүү дээ. Яг л “Өндөр ээж” кинон дээр гардаг шиг айлд орохоор сайхан хооллож ундаалж явуулна. Аав энэ олон хөвгүүдээсээ миний дээд талын ахыг л жолооч болгосон. Тэр ах маань уран жолоодлогын мастер болж байлаа. Бусдыг нь бүгдийг нь дээд мэргэжил эзэмшүүлж, хоолонд нь хүргэсэн дээ. Аав биднээс зөвхөн онц сурахыг л хүснэ. Хичээлээ хийсэн үү, ном уншиж байна уу, онц сураарай л гэнэ. Үүний дүнд жолоочийн олон хүүхэд бүгд л онц сурч, багш, хуульч, эдийн засагч гээд сэхээтэн болцгоож, улс орныхоо хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулаад явж байна.

Харин ээж маань англи, хятад хэлтэй хүн байсан. НАХЯ-нд орчуулагч хийдэг. Ээжийнхээ хэлний авьяасыг бид дууриасан. Гадаад хэл их амархан сурна. Мөн төрөл бүрийн сайхан хоол хийнэ. Ээжийнхээ хоол хийхийг би хараад л зогсдог байсан сан. Ээждээ тусална. Гэхдээ шалихгүй ээ. Би ажилд маруухандуу. Аав намайг “Бээлийтэй гартай” гэдэг байсан. Бас аавынхаа хөлд нь унтдаг болохоор “Хөлийн бор” гэнэ.

-Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Сүхбаатарын гурван удаагийн одонт аавын хүү гэж хэлүүлэх үнэхээр гоё байх даа.

-Аавын нөр их хөдөлмөр шингэсэн одонгууд. Сүхбаатарын одонг дөрөв дэхийг нь өгөх асуудал яригдсан юм билээ. Гэтэл тэр үеийн нам төрийн удирдагч Ю.Цэдэнбал Сүхбаатарын гурван одонтой гээд асуудлыг хаасан гэдэг. Өөр олон медаль бий. Алтангадас, гавшгайч гээд л. Энгэр дүүрэн одон медальтай аав. Ээж маань эхийн 1,2-р зэргийн одонгоо зүүхээр их гоё харагддаг сан. Эмэгтэй хүний бахархал юм даа.

Сайн эхнэр амжилттай яваа эрчүүдийн 50 хувь гэж францчууд хэлдэг. Аавын амжилтын тал хувийг ээж үүрсэн. Түүний хүчинд аав арагш санаа зоволтгүй явдаг байсан. ЗИЛ-130 ногоон машинтай. Хоёр чиргүүл чирээд л хөдөөгийн ард иргэдэд хоол хүнс, ачаа бараа хүргэхээр эх орны дөрвөн зүгт өдөр шөнөгүй явдаг хүн байсан даа.

Маш нямбай, тиймдээ ч машинаа нэг удаагийн их засварт оруулалгүйгээр нэг сая км-ийг туулж, Саятан жолооч нэр авсан. Аавын минь машины тормоз нь хутга шиг болчихсон байсан гэдэг.

-Дандар баатар аавын тань найз байсан гэдэг.

-Аав найз олонтой хүн байсан. Нэг нь Дандар баатар. Сайхан дуулна. Эхнэр нь ч мөн адил. Гомбосүрэн гуай эхнэртэйгээ бас сайхан дуулна. Архангай аймгийн хүмүүс. Аавыг хөдөөнөөс ирэхээр манайд найзууд нь цуглана, дуулж

хуурдана. Ээж төрөл бүрийн хоол хийж, зочдоо дайлна. Харин би ширээн доогуур орчихоод яриаг нь сонсож, дууг нь дагаж дуулсаар бүх дууг мэддэг болчихсон байсан. Эгч, ах нар бүгд томчуудын дууг мэддэг, дуулдаг байлаа.

-Бага насны санаанаас гардаггүй дурсамжаасаа хуваалцана уу?

-Тэр үед мөнгө тоглох, гэвэг өшиглөх гэсэн тоглоомууд хөвгүүд тоглодог. Драмьн театрын өмнө хүүхдүүдтэй мөнгө тоглож би 6-7 хайрцаг задгай мөнгө хураасан юм. Анх удаа өөрийн хөрөнгөтэй болсон хэрэг. Тэрийгээ аав,

ээж, ах нараас нууж, их л далд газарт нуусан юм. Гэтэл нэг өдөр баригдчихав. Том асуудал үүссэн дээ. Маш их хугацаа зарцуулж, их хөдөлмөр гаргасан хөрөнгөө хураалгачихав. Өвлийн хүйтэнд өдөржин тоглож, гараа хөлдөөн байж олсон хөрөнгө мөнгийг минь нүдний өмнө хураагаад авсанд би ихэд гомдож, том том нулимс гоожуулан мэлмэрэн мэлмэрэн уйлж билээ. 5-р ангид л байсан санагдана.

-Танайхан хэлний авьяастай гэсэн. Та англи хэлийг бие даан сурсан хүн.

-Би нийслэлийн 33-р дунд сургуулийг төгссөн. Орос хэлдээ сайн сурагч байсан. Орос хэлээр бүх номыг уншина. Оюутан байхдаа ч тэр, эрдэм шинжилгээний хурлуудад түрүүлнэ. Ангийнхандаа орчуулга хийнэ. “Болд хэрхэн хатаагдсан нь” номыг орос, монгол, англи хэлээр харьцуулан уншиж байлаа. Орос хэлний олимпиадад түрүүлнэ. Англи хэлийг бол бие даан үзсэн дээ. ■

**ЗИЛ-130 ногоон машинтай.
Хоёр чиргүүл чирээд л
хөдөөгийн ард иргэдэд
хоол хүнс, ачаа бараа
хүргэхээр эх орны дөрвөн
зүгт өдөр шөнөгүй
явдаг хүн байсан даа.
Маш нямбай, тиймдээ ч
машинаа нэг удаагийн их
засварт оруулалгүйгээр
нэг сая км-ийг туулж,
Саятан жолооч нэр авсан.**

Дурсамж

Танхимыг хариуцсан сэтгүүлч Танхимын **сэтгүүлч** болсон нь

Би 2000 онд “Өнөөдөр” сонины Эдийн засгийн албаны сэтгүүлчээр ажиллаж эхэлсэн цагаас С.Дэмбэрэл даргыг мэдэх болсон билээ. Миний хариуцдаг байгууллагуудын нэг нь Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим байсан юм. Тухайн салбарыг хариуцна гэдэг нь ор төдий зүйл биш байлаа. Өглөө бүрийн шуурхайгаар салбарынхаа талаар, байгууллагын үйл ажиллагааны тухай шинэ мэдээ мэдээлэл хэлэх ёстой. “Өнөөдөр” сонины Ерөнхий эрхлэгч Ц.Балдорж “Хариуцсан салбарынхаа сайдууд, удирдлага дарга нарыг хаана юу хийж явааг мэдэж байх ёстой” гэсэн шаардлага тавьдаг байв. Тиймээс би Танхимын талаар мэдээлэлтэй байхын тулд маш сайн харилцаатай байх ёстой болж байгаа юм. Энэ ч үүргээ би сайн биелүүлж, Танхим дээр болж буй бүх л үйл явдлын талаар мэдээлдэг, бичдэг байлаа. С.Дэмбэрэл даргатай хийсэн ярилцлага сонины эхний нүүрээс эхлээд арагш давж бүтэн нэг нүүрээр орно. Улс орны эдийн засаг, бизнесийн орчин, төрийн бодлого гээд л үнэхээр авууштай, өгүүлбэр бүр нь үнэтэй санааг агуулсан ярилцлага болдог байв. Ц.Балдорж Эрхлэгч маань нэг удаа “С.Дэмбэрэл бол шинэ санааны үүр уурхай шүү дээ. Танхимын даргыг тамхийг нь татуулж байгаад сайхан ярилцлага аваад ирээч” гэж надад үүрэг өгч байв. С.Дэмбэрэл дарга ч өрөөндөө тамхиа татаж байгаад ярьж өгнө шүү дээ.

2000-аад онд МҮХАҮТ ид цэцэглэн хөгжиж байсан. С.Дэмбэрэл даргын удирдлага дор Танхим хүчирхэгжиж, гадаад дотоодын нэр хүнд нь өсч, хувийн хэвшлийнхэн ч нэгдэн нийлж, төр засаг ч Танхимын ач холбогдлыг мэдэрч, төр хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох эхлэлүүд тавигдаж байлаа. Сэтгүүлчид бидний хувьд ч С.Дэмбэрэл даргаас яриа авах бол маш үнэтэй ярилцлага, мэдээлэл болдог байв. Нийгэмд Танхимын болоод хувийн имиджийг бүрдүүлж, үнэ цэнийг ийн бий болгн өсгөж байсан хүн бол С.Дэмбэрэл дарга байв.

Танхимын сэтгүүлч болсон нь

С.Дэмбэрэл дарга нэг өдөр над руу утасдлаа. “Чи манай Танхимын дэргэдэх “Бизнес ба Хөгжил” сэтгүүлийн Эрхлэгчээр ажиллах уу” гэж. Би огтхон ч юм бодолгүйгээр “Миний хувьд “Өнөөдөр”

сониноосоо гарах бодолгүй байна” гэв. Гэтэл “Чи хэзээ нэг өдөр манайд ажиллахыг хүсвэл манай хаалга нээлттэй шүү” гэв. Түүний хувьд одоо биш юмаа гэхэд нэг л өдөр намайг ажлаасаа гарна гэдгийг мэдэж байж. Харин би сониндоо л байна гэж бат бодчихсон хүн явсан юм.



С.Дэмбэрэл
Д.Бэхбаяр нар
2004 он.

Ингээд би энэ ярианаас хойш таван жилийн дараа С.Дэмбэрэл дарга руу утасдав. “Таны санал хэвээр үү” гэжэд тэрбээр “хэвээр” гэснээр би Танхимын ажилтан, “Бизнес ба Хөгжил” сэтгүүлийн эрхлэгч болсон юм.

Би Танхимд 2009-2010 онд ажилласан. Нэг жил ажиллах хугацаандаа “Бизнес ба Хөгжил” сэтгүүлийг шинэчлэн сайжруулахын төлөө, түлхүү агуулгыг баяжуулахад ихэд анхаарсан. 2010 онд МҮХАҮТ-ын үүсэн байгуулагдсаны 50 жилийн ой тохиож, тусгай дугаар гаргах, ойн арга хэмжээнүүдэд гар бие оролцсон жил болж өнгөрсөн билээ. Нэгхэн жил ажилласан гэхэд Танхимын хамт олон надад нэгэн арван хамтдаа ажилласан мэт хандаж ирсэнд гүнээ талархдаг.

С.Дэмбэрэл даргын хувьд Эдийн засаг, зах зээлийн хүрээлэнгүүдэд ажиллаж байсан судлаач, эдийн засагч. Улс орны хөгжил, эдийн засгийн төлөвийг мэргэжлийн үүднээс харж, баримт тоо дээр тулгуурлан ярьдаг том эдийн засагч хүн гэж ▶

▶ “Өнөөдөр” сонины сэтгүүлчийн зүгээс үнэлж харилцдаг байв. Харин Танхимд ажилласнаар илүү өөр өнцгөөс үнэлэхэд хүрсэн билээ. Танхимынхан С.Дэмбэрэл даргыг “Дарга” гэж л дуудна.

Дарга бол Монголын хувийн хэвшлийг нэгтгэсэн Танхимыг 10 гаруй жил тогтвортой удирдсан удирдагч. Дарга бол улс орны хөгжлийн ирээдүйн төлөвийг лавтайяа 10 жилээр урьдчилан хардаг байсан. Тэрбээр 2010-аад онд ногоон эдийн засаг ярьж, хэлж, төрд зөвлөж байсан юм. Хүрэн эдийн засгаас ногоон руу шилжих хэрэгтэй, эрх зүйн орчныг бүрдүүлж, ногоон хөгжлийн төлөө төр, хувийн хэвшил хамтран ажиллах талаар чухалчлан ярьдаг байв. Энэ үүднээсээ Танхимынхаа бодлогод ногоон хөгжлийн концепцийг суулгаж, ногоон бизнесийг дэмжих үүднээс “Ногоон зээлийн сан”-г байгуулсан. Танхимын дэргэд Усны бодлогын зөвлөлийг байгуулж, нарийн бичгийн даргаар намайг томилсноор би усны салбарынхантай холбогдож, уулзалт хэлэлцүүлгүүд хийж эхэлсэн юм.

Тухайн үед төр засгаас ногооны тухай ярьдаггүй байсан үе л дээ. Харин ойрын хоёр жилээс л ногоон хөгжил, ногоон шилжилтийн тухай дээр дооргүй ярьж эхэлсэн шүү дээ. Дараагийн нэг сэдэв бол төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай мөн л 2000-гаад оноос ярьж, хууль эрх зүйн орчныг бий болгоход анхаарч ирсэн. Бизнесийн орчныг сайжруулах, хувийн хэвшлээ дэмжих, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх гэдэг талаар маш их ярьж хэлж, үглэж ирсэн хүн.

Даргаас би олон зүйлд суралцсан. Даргын хэлсэн нэг зөвлөгөөг одоо ч би үргэлж санаж явдаг. Тэрбээр “Хүнийг ажилд авах амархан, халах хэцүү” гэж билээ. Үнэхээр л ажилтныг халах тушаал гаргах хүнд гэдгийг удирдах түвшинд олон жил ажиллахдаа мэдэж авсан юм.

Би улс орон ногоон хөгжил рүү тэмүүлэн ажиллах ёстой гэсэн бодлогыг нь ойлгон авч, өөрийн ажилдаа нэвтрүүлэн яваа. 2011 онд Монголын эдийн засаг, бизнесийн “Mongolian Economy” сэтгүүлийг үүсгэн байгуулахдаа Ногоон хөгжлийн төлөө уриаг дэвшүүлэн ажиллаж ирлээ. Өнөө ч энэ бодлогыг барьж, Ногоон хөгжил мэдээллийн платформыг бий болгож, ногоон хөгжлийн тухай бодлого тодорхойлогчид болоод хувийн хэвшил, олон нийтэд зөвөөр танин мэдүүлэхийн төлөө явж байна.

Танхимын “Бизнес ба Хөгжил” сэтгүүлийн Эрхлэгчээр ажиллаж байгаад “Mongolian Economy” сэтгүүлийг байгуулаад явахад Танхимын зарим ажилтан жаахан дургүйцсэн байх. Харин Дарга бол намайг дэмжсэн юм. Би түүнд ингэж

С.Дэмбэрэл даргын удирдлага дор Танхим хүчирхэгжиж, гадаад дотоодын нэр хүнд нь өсч, хувийн хэвшлийнхэн ч нэгдэн нийлж, төр засаг ч Танхимын ач холбогдлыг мэдэрч, төр хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох эхлэлүүд тавигдаж байлаа.

хэлсэн. “Дарга аа би Танхимынхаа сэтгүүлийг нэг жилийн хугацаанд сайн хийхийг хичээлээ. Гэхдээ таны хүссэн сэтгүүлийг Танхимаас гарч байж хийж чадна” гэж. Учир нь ямар нэг төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх сэтгүүл, сонин хэвлэл жинхэнэ утгаараа сэтгүүл зүйн бүтээл болж явахад хүнд юм байна гэдгийг би ойлгосон хэрэг л дээ. Ганцхан жишээ дурдахад, Танхимын санхүүгийн албанаас надад сэтгүүлд реклам л олон оруулах шаардлага тавьдаг байсан. Харин миний хувьд сэтгүүлийн агуулга сайжирч байж реклам орж ирэх нөхцөл бүрдэнэ гэж үзэж байв.

Дарга ажилтнуудаа чанга дуугарч загнадаггүй удирдагч. Маш зөөлөн дуугаар учирлана. “Та нар харахад амьд, дотроо бол үхсэн мэт” гэж нэгэн хурал дээр ажилтнуудаа зэмлэв. Ажилтнууд үргэлж шинийг санаачилж, нэвтрүүлж, шинэ соргог зүйл бодож явах ёстой. Гэтэл өглөө ажилдаа ирээд орой хурдан болоосой гэж ажилладаг гэж ярьсан нь санаанд тодхон үлдэж.

Дарга өөрөө үргэлж шинийг санаачилж, шинэ санаа оноо гаргаж, нэвтрүүлдэг манлайлагч. Өнөөгийн Танхимын үндэс суурийг тавихад түүний санаачилсэн олон ажил бодит биелэл болж, хэрэгжиж ирсэн билээ.

Дарга маш сайхан хувцаслана. Ажилтнууддаа ч ийм шаардлага тавина. Өөрсдийгөө бас бизнес эрхлэгчдээ хүндэлж зөв сайхан хувцаслах ёстой, биеэ зөв авч явах дотоод дүрэм үйлчилнэ. Танхимаас зохион байгуулж буй ямар нэг арга хэмжээг маш өндөр түвшинд зохион байгуулахыг шаардана. Монголыг гадаад, дотоодод төлөөлөхдөө үнэ цэнийг эрхэмлэж, улс төрөөс харааг бус эрхэмсэг байхын үлгэрлэлийг харуулж ирсэн байдаг. Тиймээс ч МҮХАҮТ үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойгоо “Эрхэмсэг оршихуйн 50 жил” уриан дор тэмдэглэсэн билээ.

Харин МҮХАҮТ-ын үүсэн байгуулагдсаны 65 жилийн ой энэ онд тохиож байна. Танхим өнөөдөр 6000 гаруй гаруй гишүүн байгууллагатай, 21 аймагт салбар танхимтай, 20 гаруй улсад 50 орчим төлөөлөгчтэйгээр үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг төлөөлөн хамгаалах, илэрхийлэх хуулиар хүлээсэн үүрэгтэй ажиллаж байна. Бизнес эрхлэгчдийг төлөөлөн төр, хувийн хэвшлийн гүүр болж, бизнесийн орчныг сайжруулан хөгжүүлэхийн төлөө ажилладаг, гадаад дотоодод үнэ цэнийн илэрхийлэл болсон Монголын хамгийн том төрийн бус байгууллага болжээ. Ийм л байгууллагын үндэс суурийг С.Дэмбэрэл дарга тавьж, өөрийн ур ухаанаар урлан хөгжүүлсэн юм. ■

Сэтгүүлч Д.Бэхбаяр

Хүнсний хувьсгал

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа бэхэжсэн нь

Улс орнуудын үндэсний аюулгүй байдалд хүнсний салбар онцгой ач холбогдолтой байдаг. Энэ утгаараа дэлхийн улс орнууд дотоодын хүнсний үйлдвэрлэлийг дэмжих дунд, урт хугацааны бодлогыг төсөв, мөнгөний бодлоготойгоо уялдуулан тогтвортой хэрэгжүүлж, гол нэр төрлийн хүнсийг дотоодоос хангахыг зорьж ажилладаг.

Дэлхий нийтээр 2020 онд коронавируст халдварын цар тахалд өртөж, 2022 онд ОХУ, Украйны хооронд дайн гарснаас үүдэж хүнсний бүтээгдэхүүний тээвэр, нийлүүлэлтийн сүлжээ доголдож улс орнуудын хүнсний аюулгүй байдалд шууд нөлөөлснийг та бид санаж байгаа.

Манай улс ч мөн адил энэ хүндрэлтэй нөхцөл байдлыг тойроогүй, туулж гарсан. Тиймээс Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, мал аж ахуй, газар тариалангийн салбарыг дэмжих зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар Засгийн газраас “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлсэн билээ.

Энэ хүрээнд 2022 оны зургаадугаар сарын 17-ны өдөр “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоол батлагдсан.

Тус тогтоолд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах, удирдлага, зохион байгуулалтын, газар тариалангийн үйлдвэрлэлийн, мал аж ахуйн үйлдвэрлэлийн, хүнсний боловсруулах

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭ

ЭРХЗҮЙН ОРЧИН



6 үйл ажиллагаа
18 арга хэмжээ

УДИРДЛАГА
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



8 үйл ажиллагаа
17 арга хэмжээ

Хоорондоо уялдаа холбоо бүхий “Хүнсний хувьсгал”, “Тэрбум мод”, “Атрын-4 аян аян”, “Цагаан алт хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна

үйлдвэрлэлийн чиглэлээр 41 үйл ажиллагаа, 114 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. УИХ-ын 36 дугаар тогтоолоор таван жилийн бодлого, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө, санхүүжилтыг хамтатган батлуулсан юм. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх 1.7 их наяд төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг 2022-2026 оны улсын төсвөөс зээлийн хүүгийн татаас болон батлан даалт, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр бүрдүүлэв. “Хүнсний хангамж, аюулгүй байдал”-ын үндэсний хөдөлгөөний хүрээнд хийх 114 арга хэмжээний 90 хувийг ХХААХҮЯ хэрэгжүүлж, бусдыг нь 35 байгууллага, олон улсын байгууллагууд, “Хүнсний хувьсгал” ТББ, арилжааны 10 банк хамтран хууль журмын хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж байна.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд тус салбарт үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжүүдийг зөвхөн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр дэмжихээс гадна Засгийн газраас татварын бодлогоор дэмжих, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр цогц бодлого хэрэгжиж буй юм. Мөн гол нэр төрлийн 19 хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх зорилго тавьж, түүнд чиглэсэн ▶

ГАЗАР ТАРИАЛАН



11 үйл ажиллагаа
27 арга хэмжээ

МАЛ АЖ АХУЙ



6 үйл ажиллагаа
21 арга хэмжээ

ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ



10 үйл ажиллагаа
33 арга хэмжээ

5 ЧИГЛЭЛ, 41 ҮЙЛ АЖИЛЛАГАА,
114 АРГА ХЭМЖЭЭ

► бодлогын арга хэмжээнүүд авч байна. Үр дүнд нь 53 үйлдвэр шинээр баригдаж, импортын хамаарал тодорхой хэмжээгээр буураад байгаа юм. Түүнчлэн хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Ургамал хамгаалал, ургамлын эрүүл мэндийн тухай хууль батлагдаж, Хөдөө аж ахуйн тухай хууль, Тариалангийн даатгалын тухай хуулийн төсөл боловсруулах шатанд явж байгаа юм байна.

Монгол Улс хөдөө аж ахуй, эрчим хүч, дэд бүтэц, эрүүл мэнд зэрэг нийгэм, эдийн засгийн голлох салбаруудын бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж буй. Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Цагаан алт”, “Атрын-4 аян” зэрэг үндэсний хөдөлгөөнүүдийг санаачилж, улс орон даяар хэрэгжүүлж байгаа бөгөөд төр, хувийн хэвшил, баялаг бүтээгчид, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид, ард иргэд идэвхтэй оролцож, хамтран ажиллаж байна. Тухайлбал, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарьж, арчлан ургуулснаар ойн хомсдол, доройтлыг бууруулах, усны нөөц, хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тогтвортой санхүүжилтийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байгаа юм.

“Хүнсний хувьсгал”-д 35 төр болон төрийн бус байгууллага нэгдэв

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Хөрс эрүүл бол хүнс эрүүл, хүнс эрүүл бол монгол хүн эрүүл. Энэ гурав хоорондоо хүйн холбоотой” гэдэг уриагаар “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнийг эхлүүлж байв. Энэ хүрээнд хоорондоо уялдаа холбоо бүхий “Тэрбум мод”, “Атрын-4 аян”, “Цагаан алт хөтөлбөр”-ийг мөн хэрэгжүүлж байгаа юм. Энэ талаар Ерөнхийлөгч “Хөрс сайн байж эрүүл хүнс бий болно. Тиймээс хөрсөө хамгаалахын тулд мод тарих ёстой. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн үүнтэй холбоотой. Олон улсын байгууллагууд манай хөдөлгөөнийг дэмжиж, үлгэр жишээ авдаг болсон байна. Энэ хүрээнд үндэсний үйлдвэрлэгчид хөрсөө хамгаалах, байгаль орчноо хамгаалах чиглэлд санаачилга гаргаж байгаад баяртай байна. Бид 100, 100 жил мод тарьж ойжуулах ёстой юм билээ. Тэгээд хүнс нь эрүүл хөрсөнд ургах ёстой юм. Бид дотоодынхоо хүнсний хэрэгцээг хангадаг болох хэрэгтэй. Үүний зэрэгцээ хүнс экспортлогч орон болъё гэсэн зорилт дэвшүүлсэн. Энэ боломжтой” хэмээн ярьсан.


“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн хэрэгжээд 3.5 жил болж байна. Энэ хугацаанд Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа жинхэнэ утгаараа хэрэгжиж, олон төрлийн арга хэмжээ нь очих ёстой эзэддээ хүрсээр байна. ■

Зээлийн үр дүн

Газар тариалангийн салбар


Зоорь
15%

37 мян.тн
багтаамж




Үтрэм
7%

34 мян.тн
багтаамж



Хүлэмж
18-24%


Зуны **27** га
Өвлийн **7** га



■ Зуны хүлэмж ■ Өвлийн хүлэмж

Талбай
13%

111 мян.га
талбай /2024/




Боловсруулах үйлдвэрлэл **68%** ↗



Үндсэн ангилал	Суурь	Өөрчлөлт	Өсөлтийн хувь
Мах боловсруулах, консервлох	347.5	494.9	142%
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	41.2	15.1	37%
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	340.2	150.8	44%
Үр тарианы гурилын болон цардууллаг бүтээгдэхүүн үйлдвэрлэл	273.8	81.3	30%
Хүнсний бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл	375.3	200.2	53%
Нийт	1,378.0	942.2	68%

Эх сурвалж: Салбарын мэдээлэл, ҮСХ, ХХААХҮЯ

Ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспорт (2022-2025.09.02)



Сүүний урамшуулал

(2017-2025.10.13)


	2022-2023 он	2024-2025 он	
	15	31	30% ↗
	7878	9920	10% ↗
	12,0 сая литр	18,9 сая литр	17% ↗
	6.0 тэрбум	18,9 тэрбум	30% ↗

Сүүний үйлдвэрлэл мян.тн

	2021	2024*
Шингэн сүү	53.6	59.6
Өтгөн цөцгий	4.0	7.7
Аарц	3.8	6.3
Зайрмаг	10.3	15.1
Тараг	25.2	23.2
Өрөм, зөөхий	4.0	2.7
Хуурай сүү	43.0	30
Хоормог	0.0	0.2
Бяслаг	0.1	0.7


Нийт зээл олгосон дүн

2023, 2024 он, тэрбум төгрөгөөр



Нийт зээл олгосон аж ахуйн нэгжийн тоо


2024 он
1198



2023 он
1962

Зээл олголт аймгаар

/Тэрбум төгрөг төгрөг/



Эх сурвалж ХХААХҮЯ

Аялал жуулчлал

Монголын аялал жуулчлалын үнэ цэн

“Ковид-19” гэх урилгагүй зочноос болоод тэг зогсож, уналтад ороод байсан аялал жуулчлал сүүлийн хоёр жилийн хугацаанд эрчимтэй сэргэж салбарынхан тун завгүй ажиллаж байна. НҮБ-ын Аялал жуулчлалын байгууллага (UNWTO)-ын мэдээлснээр 2024 онд олон улсад 1.4 тэрбум жуулчин зорчсон нь 2019 оны түвшнээс 99 хувиар сэргэсэн гэж дүгнэсэн. Үүнээс харахад тус салбар цар тахлын өмнөх түвшиндээ бүрэн эргэн орж эдийн засгийг тэтгэгч чухал “байр суурь”-аа эргүүлэн авчээ.

Жуулчдын зочид буудал, тээвэр, хоол хүнс, худалдан авалт зэрэгт зарцуулж буй мөнгө бүр ажлын байр бий болгож, жижиг дунд бизнесийг дэмждэг. НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын мэдээллээр, тус салбар нь дэлхий даяар 300 гаруй сая хүнийг ажлын байраар хангаж байна. Мөн өнгөрсөн онд аялал жуулчлалын салбар ойролцоогоор 10.9 их наяд ам.долларыг дэлхийн эдийн засагт оруулсан гэх Дэлхийн банкнаас гаргасан судалгаа энэ бүхнийг нотолж байна. Түүнчлэн 2024 онд аялал жуулчлалын салбар дэлхийн ДНБ-ий ойролцоогоор 10% буюу 11.1 их.наяд ам.долларыг бүрдүүлсэн хэмээн Дэлхийн аялал жуулчлалын зөвлөлөөс (WTTC) мэдээлсэн.

Испани, Франц, Япон, Тайланд зэрэг улс орон аялал жуулчлалаа эдийн засгийн гол хөдөлгүүр болгож чадсан. Тухайлбал, Франц улс жил бүр 80 сая гаруй жуулчин хүлээн авч, 60 тэрбум ам.долларын орлого олдог бол Тайландын ДНБ-ий 20 хувь нь аялал жуулчлалаас бүрддэг байна. Эдгээр улс байгаль, соёл, технологи гурвыг уялдуулсан ухаалаг бодлого хэрэгжүүлж чадсан юм.

Дэлхийн Эдийн Засгийн Форумын гаргасан

Аялал жуулчлал нь дэлхий даяар 300 гаруй сая хүнийг ажлын байраар хангаж байна



“Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индекс-2024”-т Монгол Улс 3.57 оноогоор 119 орноос 85-р байрт жагссан. Харин “Ковид-19” цар тахлын өмнө буюу 2019 онд 140 орноос 93-р байрт эрэмблэгдэж байсантай харьцуулахад манай аялал жуулчлалын салбарт ч ахиц гарчээ.

Аялал жуулчлал зөвхөн гаднаас хүн татаж, мөнгө олох бизнес бус, тухайн улс орны байгаль орчин, соёл уламжлалаа дэлхий дахинаа түгээн дэлгэрүүлэх, сурталчлах бас нэг боломж юм. Олон улсад аялал жуулчлалын хөгжлийн үзүүлэлтээ сайжруулах, цаашлаад эдийн засгийн гол салбар болгохын тулд бид өөрсдийн боломж, давуу талаа ашиглах ёстой. Монголыг дэлхийд онцгой болгодог зүйл бол онгон зэрлэг байгаль, эртний түүх, нүүдлийн соёл, уламжлал юм.

“Монголд цаг удааширч, энерги сэргэж, сэтгэл амгалан болдог” хэмээн хэлсэн гадаадын жуулчинтай ч таарч байлаа. Нүүдлийн соёл ▶



► бол зөвхөн амьдралын хэв маяг биш, харин байгальтайгаа холбогдож тэнцвэртэй орших ухаан, философи юм. Монгол гэр, морин хуур, хөөмий, уртын дуу, цагаан идээ, тал дүүрэн бэлчих таван хошуу мал, монгол наадам бол дэлхийд дахин давтагдашгүй, соёлын үнэт өв билээ.

Говийн халуун элсэн дунд тэмээн жингийн цуваа гэлдэрч, Хангайн уулсын дунд морин хуурын аялгуу, уртын дуутай эгшиглэнэ. Хөвсгөлийн тунгалаг ус, Хэнтийн ногоон хөндий, Алтайн сүрлэг оргилууд гээд бүгд нэгэн цул мэт оршдог. Энэ бол жуулчдын сэтгэлийн гүнд хүрэх Монголын аялал жуулчлалын хүч юм.

Гэвч бид энэ үнэт зүйлийг дэлхийд бүрэн дүүрэн таниулж чадахгүй байгаа гэж хэлэхэд хилсдэхгүй биз ээ. Эко аялал, адал явдалт аялал, соёлын аялал, уламжлалт ахуйг танин мэдэх аялал зэрэг чиглэлээр бид дэлхийд өрсөлдөх

**Жуулчдын
76 хувь нь
Монголын
уламжлалт
зан заншил,
нүүдэлчин
соёл,
үзэсгэлэнт
байгальд
татагддаг**

бүрэн боломжтой.

Дэлхийн хүн амын дөнгөж нэг хувь нь нүүдлийн мал аж ахуйтай холбоотой гэсэн тоо байдаг. Гэхдээ тэдний арга ажиллагаа, ахуй амьдрал Монголын нүүдлийн соёлтой адил биш. Хэдийгээр нийгмийн хөгжлийг дагаж багагүй өөрчлөгдөж байгаа ч нүүдэлчдийн уламжлалт соёлоо өдий хүртэл хадгалсаар буй орон бол Монгол. Тиймээс нүүдлийн өв соёл нь аялал жуулчлалын маш сонирхолтой бүтээгдэхүүн юм. Харин юуг нь онцолж, яаж үзүүлэх вэ гэдэг нь маш чухал.

Монголбанк, Аялал жуулчлалын үндэсний төв хамтран 2015 онд “Монгол Улсад аялж буй гадаадын жуулчдын зардлын түүвэр судалгаа”-г хийж байсан. Уг судалгаанд оролцсон жуулчдын Монгол Улсад аялсан шалтгаан, сэтгэл ханамжийг дүгнэхэд жуулчдын дийлэнх буюу 76 хувь нь уламжлалт зан заншил, нүүдэлчин соёл болон ►

Аялал жуулчлалын олон улсын өрсөлдөх чадварын индекс 2024

Зэрэглэл	Оноо	2019 оноос хойшхи өөрчлөлт		ТТДИ-ийн дундажаас зөрүүтэй (%)	Зэрэглэл	Оноо	2019 оноос хойшхи өөрчлөлт		ТТДИ-ийн дундажаас зөрүүтэй (%)	Зэрэглэл	Оноо	2019 оноос хойшхи өөрчлөлт		ТТДИ-ийн дундажаас зөрүүтэй (%)			
		Зэрэглэл	Оноо				Зэрэглэл	Оноо				Зэрэглэл	Оноо				
1	АНУ	5.24	0	-0.5%	32.3%	41	Саудын Араб	4.23	9	5.7%	6.7%	81	Танзани	3.65	7	4.5%	-7.9%
2	Испани	5.18	0	0.9%	30.6%	42	Словени	4.22	-9	-1.2%	6.4%	82	Марокко	3.64	-12	-3.2%	-8.2%
3	Япон	5.09	0	-0.3%	28.5%	43	Рум	4.19	2	0.8%	5.7%	83	Тунис	3.60	2	1.0%	-9.2%
4	Франц	5.07	2	0.8%	28.0%	44	Литва	4.17	4	1.4%	5.2%	84	Ямайка	3.59	-1	-0.1%	-9.5%
5	Австрали	5.00	2	0.8%	26.0%	45	Гүрж	4.14	4	1.0%	4.4%	85	Монгол	3.57	-6	-2.0%	-9.8%
6	Герман	5.00	-1	-0.8%	26.0%	46	Хорват	4.13	-2	-0.7%	4.3%	86	Камбож	3.57	4	2.5%	-10.0%
7	Англи	4.96	-3	-2.4%	25.2%	47	Тайланд	4.12	-6	-2.5%	3.9%	87	Хойд Македон	3.53	-5	-1.9%	-10.9%
8	Хятад	4.94	1	1.0%	24.6%	48	Израил	4.10	-5	-1.6%	3.4%	88	Молдав	3.53	1	1.0%	-11.1%
9	Итали	4.90	3	2.1%	23.5%	49	Аргентин	4.10	-2	-0.6%	3.4%	89	Тринида ба Тобаго	3.52	-5	-2.1%	-11.3%
10	Швейцарь	4.81	-2	-2.3%	21.3%	50	Колумб	4.08	6	2.3%	3.0%	90	Босни Герцеговина	3.51	1	1.1%	-11.5%
11	Канад	4.81	-1	-1.1%	21.2%	51	Коста Рика	4.08	4	2.2%	2.9%	91	Лаос	3.48	2	1.7%	-12.1%
12	Португал	4.78	1	-0.1%	20.6%	52	Казахстан	4.07	6	3.7%	2.6%	92	Парагвай	3.47	0	0.8%	-12.5%
13	Сингапур	4.76	-2	-1.7%	19.9%	53	Катар	4.02	-7	-3.3%	1.3%	93	Руанда	3.45	6	2.6%	-12.9%
14	Солонгос	4.74	0	1.1%	19.6%	54	Бүгд Найрамдах Словак	4.00	-2	-0.2%	0.8%	94	Болив	3.45	3	2.1%	-12.9%
15	Австри	4.65	0	-0.5%	17.4%	55	Өмнөд Африк	3.99	7	3.4%	0.7%	95	Намиби	3.45	-8	-1.7%	-13.0%
16	Нидерланд	4.64	1	0.1%	17.0%	56	Азербайжан	3.98	-5	-0.6%	0.3%	96	Кувейт	3.44	-10	-2.9%	-13.2%
17	Денмарк	4.63	-1	-0.9%	16.8%	57	Маврики	3.98	-4	-0.7%	0.3%	97	Эль Сальвадор	3.43	4	4.0%	-13.4%
18	Арабын нэгдсэн Эмират улс	4.62	7	4.4%	16.5%	58	Бахрейн	3.96	3	2.1%	-0.1%	98	Алжир	3.42	2	2.6%	-13.6%
19	Швед	4.57	0	0.7%	15.4%	59	Вьетнам	3.96	4	3.2%	-0.2%	99	Тажикстан	3.42	-3	0.7%	-13.7%
20	Финланд	4.52	-2	-1.7%	14.0%	60	Монтенегро	3.96	-1	0.9%	-0.2%	100	Гватемал	3.42	-5	0.5%	-13.8%
21	Грек	4.52	5	2.6%	13.9%	61	Египет	3.96	5	4.3%	-0.2%	101	Пакистан	3.41	3	3.6%	-14.0%
22	Индонез	4.46	14	4.5%	12.4%	62	Перу	3.90	7	3.5%	-1.5%	102	Киргиз	3.38	1	2.8%	-14.7%
23	Белги	4.45	0	-0.5%	12.2%	63	Панам	3.90	-6	-1.2%	-1.6%	103	Венесуэл	3.34	-5	-0.9%	-15.7%
24	Ирланд	4.44	-3	-1.5%	12.0%	64	Доминикан	3.88	1	1.8%	-2.0%	104	Замби	3.34	-2	1.4%	-15.7%
25	Шинэ Зеланд	4.41	-5	-2.6%	11.3%	65	Латви	3.88	-11	-3.0%	-2.1%	105	Непал	3.34	0	2.8%	-15.7%
26	Бразил	4.41	8	3.3%	11.2%	66	Албани	3.87	12	5.9%	-2.4%	106	Гана	3.28	1	1.5%	-17.2%
27	Польш	4.40	3	2.0%	11.1%	67	Оман	3.87	-7	-1.2%	-2.5%	107	Сенегал	3.24	2	2.5%	-18.2%
28	Люксембург	4.40	-4	-0.9%	10.9%	68	Серби	3.86	3	2.7%	-2.8%	108	Никарагуа	3.24	-2	0.0%	-18.3%
29	Турк	4.39	8	3.1%	10.6%	69	Филиппин	3.84	-2	1.7%	-3.1%	109	Бангладеш	3.19	2	3.0%	-19.5%
30	Кипр	4.37	-3	-0.4%	10.4%	70	Жордан	3.81	2	2.0%	-4.0%	110	Зимбабве	3.19	0	2.5%	-19.6%
31	Чили	4.33	4	1.4%	9.2%	71	Уругвай	3.79	-3	0.4%	-4.3%	111	Гондурас	3.19	-3	-1.4%	-19.6%
32	Исланд	4.32	-10	-3.4%	9.0%	72	Армен	3.73	-8	-2.4%	-5.9%	112	Нигери	3.18	1	4.2%	-19.8%
33	Чех	4.31	-2	0.3%	8.8%	73	Иран	3.72	4	1.5%	-6.3%	113	Бенин	3.16	-1	3.3%	-20.4%
34	Мальта	4.30	4	1.1%	8.4%	74	Барбадос	3.71	-1	-0.4%	-6.5%	114	Кот-д'Ивуар	3.13	2	6.4%	-21.0%
35	Малайз	4.28	-7	-2.2%	7.9%	75	Ботсвана	3.71	6	2.5%	-6.5%	115	Малави	3.06	0	2.8%	-22.8%
36	Эстони	4.28	4	0.7%	7.8%	76	Шри Ланка	3.69	-1	0.0%	-6.8%	116	Ангол	3.05	-2	1.3%	-22.9%
37	Унгар	4.27	5	1.7%	7.7%	77	Кени	3.68	-1	0.1%	-7.1%	117	Камерун	2.99	0	3.1%	-24.6%
38	Мексик	4.26	-6	-0.6%	7.4%	78	Узбекистан	3.68	16	7.8%	-7.3%	118	Сьерра Леон	2.89	0	2.7%	-27.1%
39	Энэтхэг	4.25	-10	-2.1%	7.1%	79	Ливан	3.66	1	0.8%	-7.6%	119	Мали	2.78	0	-0.4%	-30.0%
40	Болгар	4.25	-1	0.0%	7.1%	80	Эквадор	3.66	-6	-1.0%	-7.6%						

● Америк тив ● Ази-Номхон далайн ● Европ ба Еврази ● Ойрхи Дорнод ба Хойд Африк ● Сахарын цөлөөс Өмнөх Африк

Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форум

► үзэсгэлэнт байгаль, зэрлэг ан амьтанд татагдсан гэжээ. Зөвхөн байгаль үзүүлэх биш, туршлага, мэдрэмж, оролцоог бий болгох нь хамгийн чухал. Гадаадын жуулчин монгол гэр барих, айраг, цагаан идээ боловсруулах, морь унах, хонь хариулах, тугал хаших зэрэг Монголын мал аж ахуй, нүүдэлчин ардын амьдралыг өөрийн биеэр мэдрэхийг хүсдэг. Энэ л үед жуулчин Монголыг зүгээр нэг үзээгүй, харин “амссан, амьсгалсан, мэдэрсэн” байдаг.

Үүний тулд нутгийн иргэдийн оролцоо

хамгийн чухал. Учир нь жуулчдын үзэж харах, мэдэрч турших бүхий л туршлага тухайн нутгийн иргэдийн оролцоотойгоор бүтнэ. Өөрсдийн уламжлалт соёлыг, аж ахуй, амьдралын хэв маягийг жуулчдад танилцуулснаар аяллын үнэ цэн нэмэгдэж, зөвхөн эдийн засгийн бус соёлын ач холбогдолтой.

НҮБ-ын ДАЖБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын алба хашиж байсан Талеб Рифай 2019 онд манай улсад айлчлах үеэрээ “Монгол Улсын аялал жуулчлалын салбарт нүүдлийн буюу “nomad-►

► ic” брэнд томоохон байр суурь эзэлдэг. Тиймээс энэхүү брэндээ дэлхийд сурталчлан таниулж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өмчилж авах хэрэгтэй” хэмээн онцлон хэлсэн.

Энэ бүхний хэрэгжүүлэхэд үндэсний хэмжээний бодлого, дэд бүтэц, хууль, эрх зүйн таатай орчин, мэргэшсэн, чадварлаг хүний нөөц бидэнд маш чухал. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ийг хэрэгжүүлэх, эдийн засгийг солонгоруулах, аялал жуулчлалын салбарыг тэргүүлэх чиглэл болгох, цаашид Монгол Улсад дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй уялдуулан 2023-2028 оны Монголд зочлох жил болгон зарласан. Түүнчлэн 2030 он гэхэд бид хоёр сая жуулчин хүлээн авах зорилт тавьсан. Ингэснээр Монгол Улсын ДНБ-ий 10 орчим хувийг аялал жуулчлалын салбараас бүрдүүлэх, цаашид эрчимтэй хөгжиж буй олон улсын зах зээлийг Монголд илүү төвлөрүүлэх шаардлагатай гэж үзсэн. Үүний тулд энэ салбарт ойролцоогоор 11 орчим их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гэж тооцоод байгаа юм.

Түүнчлэн Монголын аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэхэд хөдөө, орон нутгийн иргэдийн оролцоо маш ач холбогдолтой. Учир нь жуулчдын үзэж харах, мэдэрч турших бүхий л туршлага тухайн нутгийн иргэдийн оролцоотойгоор бүтдэг. Иргэд өөрсдийн уламжлалт соёл, аж ахуй, амьдралын хэв маягийг жуулчдад танилцуулснаар аяллын үнэ цэн нэмэгдэнэ. Орон нутгийн иргэд гар урлал, аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхдээ зөвхөн орлого олох төдийгүй байгаль, соёлоо хамгаалах ухамсартай болж, нутгийнхаа өвөрмөц соёлыг хадгалан түгээнэ. Иймд Монголын аялал жуулчлалын бодлогыг төлөвлөх, бүтээгдэхүүн хөгжүүлэхдээ орон нутгийн иргэдийг идэвхтэй оролцуулах, тэдний ур чадвар, уламжлалыг дэмжих системийг бий болгох шаардлагатай. Аялал жуулчлал зөвхөн жуулчдын үзэж харах зүйл биш, орон нутгийн иргэдийн сэтгэл, бүтээмж, соёлын амьдралтай салшгүй холбоотой билээ.

Засгийн газраас аялал жуулчлалыг бүс, орон нутгийн онцлогт нийцүүлж, байгаль, түүх, соёлын өвд түшиглэн Баруун бүсэд адал явдалт, тусгай сонирхлын, Хангайн бүсэд-байгалийн, амралт

**Монгол Улс
2030 он
гэхэд хоёр
сая жуулчин
авах зорилт
тавьсан.
Үүний тулд
энэ салбарт
ойролцоогоор
11 орчим
их наяд
төгрөгийн
хөрөнгө
оруулалт
шаардлагатай**


зугаалгын, Говийн бүсэд палеонтологийн, Төвийн болон Улаанбаатарын бүсэд соёл бизнесийн, Зүүн бүсэд түүхэн төрөлжсөн аялал жуулчлал, түүнийг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, үндэсний брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлэхээр төлөвлөж байгаа.

Ямартаа ч бид жуулчдыг эх орон руугаа татаад эхэлсэн. 2024 онд манай улс түүхэн дээд амжилт тогтоож хамгийн олон жуулчин хүлээн авсан. Цаашид ч энэ тоог өсгөхийн тулд аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон үндэсний шинэлэг, сор бүтээл, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай.

Гэвч сайны хажуугаар саар зүйл ч олон байна. Монголын зам тээвэр, дэд бүтэц муу, зочид буудал, жуулчны баазын стандарт жигд бус, төр-хувийн хэвшлийн уялдаа сул зэрэг бодит байдал дээр салбарыг хөгжүүлэхэд тулгамдсан асуудал олон бий. Олон улсын аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индексээр манай хамгийн их оноо алдсан үзүүлэлт нь агаар болон газрын дэд бүтцийн сул хөгжил. Цаашлаад 21-р зууны технологийн эрин үед бид модон жорлонгоосоо салаагүй байгаа. Модон жорлонгийн асуудал Монголыг зорьж ирсэн гадаадынхны нүдийг бүлтийлгэхэд хүргэдэг нь үнэн. “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т аюулгүй байдал, даатгал, стандартчиллын асуудлыг тусгасан ч хэрэгжилт, хяналт нь бодит байдал дээр хангалтгүй байна. Ялангуяа адал явдалт аяллын төрөлд хамаарах шүхрийн нислэг, уулын спорт, морин болон мотоциклын аялал зэрэг нь онцгой эрсдэл дагуулдаг тул өндөр зохицуулалт шаарддаг. Гэвч эдгээр үйл ажиллагаа ихэнхдээ стандартгүй, даатгалгүй, мэргэшсэн боловсон хүчингүй, зөвшөөрөлгүй явагдаж байна. Үүний улмаас жуулчид осолдох, гэмтэж бэртэх, бүр амь насаа алдах эрсдэл үүсэж буй. Иймд төрийн бодлого нь зөвхөн тоо хэмжээг нэмэгдүүлэхэд бус чанарыг сайжруулахад чиглэсэн, жуулчдын эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх, хяналт шалгалт, хариуцлага тооцох механизмыг шуурхай хэрэгжүүлэх нэн шаардлагатай байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын ►

Аялал жуулчлалын хөгжлийн үзэл баримтлал ба кластерууд



► сайд Ч.Ундрам Азийн Хөгжлийн Банкны “КАРЕК” хөтөлбөрийн дарга Лазиза Сабирова тэргүүтэй төлөөлөгчдийг энэ сарын 8-нд хүлээн авч уулзжээ. Уулзалтаар тус хөтөлбөрийн хүрээнд Төв Азийн 11 орны аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэх шинэ санаачилгуудыг хэлэлцсэн байна. “КАРЕК” хөтөлбөрийн хүрээнд манай улс нүүдэлчин аялал жуулчлалын коридор байгуулахаар төлөвлөж байгаа гэдгийг салбарын сайд онцолсон. түүнчлэн Чингис хааны түүхэн газруудаас эхлэлтэй аяллын маршрут гаргах, аялал жуулчлалын салбарыг түшиглэсэн Зүүн бүсийн агаарын төв болох, сургалт, хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэхэд хамтран ажиллах зэрэг санаачилга гаргалаа. АХБ-ны “КАРЕК” хөтөлбөрийн дарга Лазиза Сабирова “Төв Азийн орнуудын хооронд хамтарсан визний хөнгөвчилсөн нөхцөл бий болгох, аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх нь бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд чухал ач холбогдолтойг онцоллоо. Мөн ирэх сард Бүгд Найрамдах Киргиз Улсын нийслэл Бишкек хотод болох “КАРЕК”-ийн гишүүн орнуудын сайд нарын уулзалтад Монгол Улсын төлөөлөгчдийг оролцохыг урьж, 2026 онд Монгол Улсад аялал жуулчлалын чиглэлд онцлох арга хэмжээ хамтран

зохион байгуулах санал гаргасан.

“КАРЕК” хөтөлбөрийн хүрээнд Төв Азийн 11 орон 2030 он хүртэл хэрэгжүүлэх аялал жуулчлалын стратегийг батлан хэрэгжүүлж байгаа. Тус стратегийн зорилго нь тогтвортой, аюулгүй, хялбар зорчих нөхцөл бүхий бүс нутгийг бий болгож, торгоны зам дагуу өвөрмөц, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгож, жилийн дөрвөн улиралд аялал жуулчлалын үйл ажиллагааг тогтвортой хөгжүүлэхэд чиглэж байна. Энэхүү хамтын ажиллагаа нь бүс нутгийн орнуудыг олон улсад танигдсан аялал жуулчлалын бүс нутаг болгон төлөвшүүлэх, иргэдэд хүртээмжтэй эдийн засгийн ашиг бий болгоход чухал түлхэц болох юм.

Уул уурхай дуусдаг баялаг, харин аялал жуулчлал хэзээ ч дуусахгүй баялаг юм. Аялал жуулчлал байгалиа хамгаалдаг, соёлоо түгээдэг, иргэддээ ажлын байр, амьдралын чанарыг дээшлүүлдэг. Монголчууд бид хайрлаж, соёлоо нандигнаж, бусдаас ялгарах ондоошлоо тунхаглаж чадвал аялал жуулчлал ирээдүйд уул уурхайг орлох хамгийн том баялаг болно. Түүнийг зөв ухаж гаргаж чадвал уул уурхайн орлогоос илүү үүрдийн баялаг бүтээх боломж бидэнд бий. ■




ӨГИЙ ДАЛАЙ РЕСОРТ



ДӨРВӨН УЛИРАЛ АЖИЛЛАДАГ



 99058699, 99083688, 80272299

 Өгий далай ресорт

ЯАП ВАН ХИЕРДЭН: Хариуцлагатай аялал жуулчлалыг хөгжүүлснээр экосистемд ирэх дарамт буурна

Байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар НҮБ-ын Монгол дахь Суурин зохицуулагч Яап ван Хиердэнтэй ярилцлаа.

-Энэ өдрүүдэд Нэгдсэн Үндэсний Байгууллага 80 жилийн түүхэн ойгоо тэмдэглэж байна. Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилт, цаашдын үйл ажиллагааны чиглэлээр НҮБ-ын Ерөнхий ассемблейгээс гаргасан шийдвэрүүдийн талаар та манай уншигчдад товч мэдээлэл өгнө үү? Тогтвортой хөгжлийн зорилт, ногоон хөгжлийн асуудлууд бол төрийн ажил гэсэн түлхүү ойлголт манайханд байдаг. Та энэ талаар ямар байр суурьтай байна вэ?

-НҮБ-ын 80 жилийн ой бол Монгол Улс болон НҮБ-ын хоорондох хамтын хөгжил дэвшил болон бат бөх хамтын ажиллагааг дүгнэх түүхэн мөч юм. Энэхүү хамтын ажиллагаа маань олон арван жилийн хугацаанд институцүүдийг бэхжүүлж, хүний хөгжлийг урагшлуульж, хүн төрөлхтөн болон дэлхий гарагийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулжээ. 2030 он ойртож буй энэ үед Тогтвортой хөгжлийн зорилгуудыг (ТХЗ) улам шуурхай хэрэгжүүлэх хүсэл эрмэлзлээ НҮБ-ын Ерөнхий ассемблей саяхан дахин нотолсон.

Үүнтэй холбоотой нэн чухал шийдвэрүүдийн тоонд хөгжлийн санхүүжилт, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааг сайжруулах, салбар болон улс хоорондын хүртээмжтэй хамтралыг нэмэгдүүлэх багтаж байна. Гол нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх нь зөвхөн засгийн газрын үүрэг хариуцлага биш юм. Үүнд бүхий л талуудын хүчин чармайлт хэрэгтэй бөгөөд иргэд, иргэний байгууллага, боловсролын байгууллага, хувийн хэвшил ихээхэн үүрэг гүйцэтгэнэ. Бизнесийн байгууллагууд нь инновац, хөрөнгө оруулалт, ажил эрхлэлтийг дэмждэг. Тэд бол ногоон технологи нэвтрүүлэх, хүртээмжтэй өсөлтийг дэмжих,



хариуцлагатай аялал жуулчлалыг хөгжүүлэх зэргээр тогтвортой хөгжлийн зорилгуудтай нийцсэн өөрчлөлтийг авчрах хүчирхэг үндэс суурь юм. ТХЗ бол зөвхөн хяналтын хуудас бөглөх үйл хэрэг биш. Энэ бол илүү сайхан ирээдүйг бүтээх гарын авлага мөн. Гэхдээ тэрхүү ирээдүйд хүрэх эсэх нь хамтын үүрэг хариуцлага, үйлдлээс шалтгаална.

-Монгол Улсын Засгийн газраас уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засгийг төрөлжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх хүрээнд аялал жуулчлалыг тэргүүлэх салбар гэж үзэж, бодлого хөтөлбөрөө чиглүүлж байгаа. Та үүнтэй санал нэгдэх үү?

-Тийм ээ, санал нийлж байна. ДНБ-ий 30 орчим хувь, экспортын 94 хувь, улсын төсвийн 33 хувь, ▶

► гадаадын шууд хөрөнгө оруулалтын 79 хувийг бүрдүүлдэг уул уурхайн салбараас Монголын эдийн засаг ихээхэн хамаардаг. Тиймээс урт хугацаанд тогтвортой хөгжихийн тулд эдийн засгаа төрөлжүүлэх нь нэн чухал юм. Үйлчилгээний салбар, нэн ялангуяа аялал жуулчлал ихээхэн ирээдүйтэй харагдаж байна. Монголын өвөрмөц байгаль, нүүдэлчин өв уламжлал, биологийн баялаг төрөл зүйл нь эко аялал жуулчлал, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх нэн таатай суурь болж чадна. Гадаадын жуулчдыг татсанаар Монгол Улс үйлчилгээний салбараа өргөжүүлэн тэлэхээс гадна хөдөө орон нутагт, тэр дундаа уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтөд өртсөн нутгуудад тогтвортой амьжиргааг бий болгох боломжтой юм.

-Энэ жилийн “ITM Mongolia 2025” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн “Тогтвортой аялал жуулчлал-Төв Ази” сэдвийн дор зохион байгуулж байгаа. Аялал жуулчлалын салбарын тогтвортой хөгжлийг хангах, бүс нутгийн эдийн засгийн интеграцийг нэмэгдүүлэх чиглэлээр Монголын аялал жуулчлалын холбоо санаачилга гаргаж энэхүү үзэсгэлэнг зохион байгуулж байна. Хувийн хэвшлийн энэхүү санаачилгыг та бүхэн хэрхэн хүлээн авч байгаа вэ?

-“Тогтвортой аялал жуулчлал-Төв Ази” сэдвийн хүрээнд ITM Mongolia 2025 арга хэмжээг зохион байгуулж байгаа Монголын Аялал жуулчлалын холбоонд баяр хүргэе. Тогтвортой хөгжлийг бий болгоход хувийн хэвшил тэргүүлэгч үүрэг гүйцэтгэж буйн нэг тод жишээ нь энэхүү арга хэмжээ болж байна. НҮБ-ын Даян дэлхийн гэрээ, НҮБ-ын Бизнес ба Хүний Эрхийн Удирдах Зарчмууд зэрэг санаачилгаар дамжуулж НҮБ бизнесүүдтэй идэвхтэй хамтран ажилладаг юм. Жишээлбэл, байнгын ажлын байраар хангах, хүртээмжтэй бизнесийн арга барил хэрэгжүүлэх зэргээр ядуурлыг устгах ТХЗ 1-ийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн үүрэг роль нэн чухал. Хариуцлагатай аялал жуулчлалыг бодлоготой хэрэгжүүлвэл экосистемд ирэх дарамт буурч, орон нутгийн эдийн засгийг дэмжиж, байгаль орчны хамгааллыг сайжруулах бүрэн боломжтой. Энэ нь хүн төрөлхтөн, байгалийн аль алинд ач тустай гэдэг нь гарцаагүй.

-Хөгжлийн стратеги, бодлогоо бид зөв төлөвлөж, удирдахгүй бол хог хаягдал, орчны бохирдол зэрэг сөрөг асуудал гардаг. Тиймээс

Гадаадын жуулчдыг татсанаар уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтөд өртсөн хөдөө нутгуудад тогтвортой амьжиргааг бий болгох боломжтой.

байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд гол анхаарах асуудлуудыг юу гэж үзэж байна вэ? Энэ чиглэлд НҮБ хэрхэн хамтран ажиллах боломжтой вэ?

-Хог хаягдал, бохирдол, экосистемийн доройтол зэрэг таагүй үр дагавараас зайлсхийхийн тулд тогтвортой аялал жуулчлалыг маш зөв төлөвлөж, хэрэгжүүлэх хэрэгтэй. Эдгээрээс хамгийн чухал нь:

- Байгаль орчныг хамгаалах: бүсчлэл, хог хаягдлын менежмент, нөлөөлөл багатай дэд бүтэц зэргээр дамжуулж эмзэг байгаль орчин, биологийн олон янз байдлыг хамгаалах.
- Иргэдийн оролцоо: аялал жуулчлалаас орон нутгийн иргэд эдийн засаг болон соёлын хувьд ашиг шим хүртдэг байх.
- Мэдлэгжүүлэх: хариуцлагатай аялах зан үйл болон байгаль орчинд бага нөлөө үзүүлэх соёлыг дэмжин сурталчлах.

НҮБ техникийн тусламж, бодлогын зөвлөгөө, чадавхыг сайжруулах замаар Монгол Улсыг дэмжиж ажилладаг. Аялал жуулчлалын төлөвлөлтөд тогтвортой хөгжлийг багтаах, эко аялал жуулчлал, орон нутагт тулгуурласан аялал жуулчлал зэрэг загварыг хөгжүүлэхэд туслахын тулд бид үндэсний болон орон нутгийн хэмжээний оролцогч талуудтай нягт хамтран ажиллаж байна.

-Байгальд ээлтэй, ногоон технологийг нэвтрүүлэх нь аж ахуйн нэгжүүдэд өндөр өртөгтэй тусдаг. Нөгөө талдаа санхүүгийн зах зээл дээр ногоон санхүүжилтийн хэмжээ ихсэж байна. Тэгвэл санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ногоон хөрөнгө оруулалтыг дэмжих олон улсын сайн жишиг, оновчтой механизм юу байна вэ? Монголд нэвтрүүлэх боломж бий юу?

- Ногоон технологийг ашиглахад эхэндээ хөрөнгө оруулалт, зардал их шаарддаг ч олон улсын туршлагаас харахад санхүүгийн зорилтот механизмууд нь хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг нээж, санхүүгийн хүртээмжийн сайжруулж эхэлсэн. Энэ талын сайн жишээнүүдээс дурдвал:
- Ногоон ангиллын тогтолцоо: Санхүүжилт авах боломжтой төслийг тодорхойлоход нь санхүүгийн байгууллагуудад туслах зорилгоор өөрийн гэсэн ногоон ангиллын ►

- ▶ тогтолцоо зэрэг ангиллын тодорхой системийг бий болгох.
- Хосолмол санхүүгийн загварууд: Концесс, баталгаа зэргийг ашиглах, эрсдэлийг бууруулахын тулд төрийн болон хувийн хөрөнгийг хослуулан ашиглах.
- Ногоон бонд, тогтвортой хөгжилтэй холбоотой зээл: санхүүгийн шалгуурыг байгаль орчны гүйцэтгэлтэй холбохын зэрэгцээ хөрөнгө татан төвлөрүүлэх.

Монгол Улс эдгээр чиглэлд ихээхэн ахиц дэвшил гаргаж байна. Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг, Ногоон ангиллын тогтолцоо болон Монголын тогтвортой санхүүжилтийн холбооны ажлууд нь тун сайн суурь болж эхэлсэн. Олон улсын тусламж дэмжлэг, дэлхийн стандартуудтай нийцүүлэх замаар Монгол Улс ногоон санхүүжилтээ улам нэмэгдүүлж, тогтвортой хөрөнгө оруулалтаас хүртэх боломжтой. Ялангуяа байгаль орчны болон эдийн засгийн үр ашиг бүхий хариуцлагатай аялал жуулчлалд энэ нь бүр их хамаатай.

-Тогтвортой хөгжлийн чиглэлд орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх гэж бий. Цөлжилт, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой уламжлалт аж ахуйгаас гадна малчдын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлага гарч байна. Аялал жуулчлал шийдэл нь байх боломжтой юу?

-Тийм ээ, боломжтой. Хэрэв зөв бодлоготой хэрэгжүүлэх юм бол аялал жуулчлал нь Монголын соёлын өв, гайхамшигт байгалийг улам үнэ цэнтэй болгох орлогын маш боломжийн эх үүсвэр болж чадна. Орон нутагт түшиглэсэн аялал жуулчлал нь уламжлал соёлоо сурталчлах, жуулчид хүлээж авах, газар нутгаа доройтуулалгүй орлого олох зэргээр малчид, орон нутгийн иргэдийг дэмжих маш зөв зүйтэй арга юм. Газарчилж аялуулах, гэртээ жуулчин хүлээж авах, эко аялал жуулчлал зохион байгуулах зэргээр хариуцлагатай аялал жуулчлалыг дэмжих замаар Монгол Улс бэлчээрийн даац хэтрэлт, хөрсний доройтол зэргээс үүдэж буй ихээхэн дарамтыг бууруулж чадна. Хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, чадавхыг дэмжих, орон нутгийн иргэд, байгууллагыг тогтвортой жуулчлалын зах зээлтэй холбох зэргээр НҮБ эдгээр хүчин чармайлтыг дэмжин ажиллаж байна.

-Хариуцлагатай аялал, аялагчийн талаар ярих нь зүйтэй байх. Зөв дадал, зуршлыг хэвшүүлэх, түгээх, сурталчлах зэргээр иргэдэд чиглэсэн ямар ажлуудыг, аль түвшинд хийвэл

Хариуцлагатай аялал нь хариуцлагатай аялагчаас эхэлдэг

Үр дүнтэй вэ?

-Хариуцлагатай аялал нь хариуцлагатай аялагчаас эхэлдэг. Олон нийтэд мэдлэг мэдээлэл олгох кампанит ажлууд, зан авирыг өөрчлөх санаачилга зэрэг нь байгаль, соёл, орон нутгийг хүндлэх сэтгэлийг суулгахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Дараах аргуудыг хэрэгжүүлбэл тун үр дүнтэй байдаг.

- Үндэсний хэмжээний кампанит ажил: хэвлэл мэдээлэл, сургууль, олон нийтийг хамарсан арга хэмжээ зэргээр дамжуулан хариуцлагатай аялал жуулчлалыг сурталчлах.
- Орон нутгийн оролцоо: хөтөч, хост айл, орон нутгийн удирдлагуудад тогтвортой аялал жуулчлалын практикийг бий болгох, хэрэгжүүлэх арга замуудыг таниулах.
- Дижитал платформууд: байгальд ул мөр үлдээхгүй аялах талаарх зөвлөгөө, түүх, зааврыг нийгмийн сүлжээ болон апп ашиглах түгээх.
- Олон улсын тэргүүн туршлагаар хангах, хамтын ажиллагааг дэмжих, ялгаатай оролцогч нарт зориулсан мессежийг бий болгох зэргээр НҮБ эдгээр санаачилгыг дэмжиж ажилладаг юм.

-ЮНЕСКО “Рио Тинто” Монгол компанийн дэмжлэгээр Өмнөговь аймагт Геопарк байгуулах төслийг эхлүүлсэн. Энэ төслийн ач холбогдлын талаар мэдээлэл өгнө үү?

-Рио Тинто компанитай хамтран хэрэгжүүлж буй "ЮНЕСКО-ийн соёлын болон геологийн өвд тулгуурлан Монгол Улсад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нь" төсөл бол маш ач холбогдолтой санаачилга юм. Уг төсөл нь Монгол Улсын соёлын болон геологийн өвд тулгуурлан Ковид-19 цар тахлын дараа аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, дэмжихэд чиглэж байна. Монгол Улсад ЮНЕСКО-гийн Олон улсын геопаркт багтсан газар байхгүй. Харин уг төсөл нь ийм газрыг бий болгоход зориулж чадавхийг нэмэгдүүлэх, олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой юм. Геопаркууд нь тогтвортой хөгжлийг дэмжиж, геологийн өвийг хадгалж, орон нутгийн эдийн засгийг хөгжүүлдэг. Үүний зэрэгцээ боловсрол, уур амьсгалын дасан зохицох чадвар, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж байдаг юм. Геопарк нь байгаль хамгаалал, орон нутгийн хөгжил, Монголын өвөрмөц ялгарлыг сурталчлахад аялал жуулчлал ямар үүрэг гүйцэтгэж болох вэ гэдгийг



► харуулсан бэлэн загвар болох юм.

-Хувийн хэвшлийн томоохон аж ахуйн нэгжүүдийн зүгээс энэхүү геопарк шиг байгаль хамгаалал, аялал жуулчлалын хөгжлийн чиглэлээр санал, санаачилга гаргавал НҮБ-аас дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах боломжтой юу?

-Тийм ээ, тогтвортой хөгжлийн зорилгуудтай нийцсэн хувийн хэвшлийн аливаа шинэлэг санаа саналыг НҮБ дуртайя дэмжинэ. Учир нь инновац бий болгох, технологийг хөгжүүлэх, дэлхийн хэмжээний сорилттой тэмцэх эх үүсвэрийг бий болгож ашиглахад бизнесүүд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж НҮБ үздэг юм. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг тухайн улсын хөгжлийн бодлогуудтай уялдуулахын тулд бид Засгийн газруудтай нягт хамтран ажиллахын зэрэгцээ тогтвортой хөгжлийг бизнесийн үндсэн үйл ажиллагаандаа шингээхэд нь компаниудад туслахыг зорьж байна. Үүний нэг тод жишээ бол НҮБ-ын Геопарк төсөл юм. Уг төсөл нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны нөлөөг тод томруун харуулж байгаа гэж бодож байна. Байгаль орчны хамгаалал, тогтвортой аялал жуулчлал, хүртээмжтэй өсөлтийг дэмжсэн аливаа хамтын ажиллагаанд бид үргэлж нээлттэй байдаг.

-Ирэх жил “СОР17” олон улсын хурлыг Монгол Улс зохион байгуулах гэж байна.

“СОР17”-ын үеэр Монгол Улс эко аялал жуулчлалын гол төв гэдгээ дэлхийд харуулах таатай боломж.

Дэлхийн 170 гаруй улсын төрийн тэргүүн, өндөр дээд хэмжээний албан тушаалтнууд, 10 гаруй мянган хүн оролцоно. Үүнээс гадна эдгээр хүмүүсийг дагаад олон улсын хэвлэл мэдээллийн агнетлагууд ирэх байх. “СОР17”-г Монгол Улс зохион байгуулах нь ямар ач холбогдолтой вэ? Хурлын бэлтгэл ажлын үеэр бид юун дээр илүү анхаарах хэрэгтэй вэ?

-“СОР17” олон улсын хурлыг зохион байгуулах нь Монгол Улсын хувьд түүхэн боломж юм. Уг арга хэмжээ Монгол Улсыг дэлхийн уур амьсгалын хэлэлцүүлгийн төвд авчирч, тогтвортой хөгжил, газрын доройтлыг нөхөн сэргээх чиглэлд манлайлж байгааг харуулах юм. Төрийн тэргүүн, өндөр дээд түвшний албаны хүмүүс, олон улсын хэвлэл мэдээлэл зэрэг нийт 7000 гаруй зочин хүрэлцэн ирнэ. Энэ бол хөрөнгө оруулалт татах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх, газрын доройтлыг сэргээх чиглэлд Монгол Улсын дуу хоолойг хүргэх арга хэмжээ юм. Энэхүү арга хэмжээний бэлтгэлд дараах зүйлс багтаж байна.

Дэд бүтэц, логистик: арга хэмжээг саадгүй явуулах, хүртээмжийг хангах.

Бодлого, мэдээлэл: Монгол Улсын уур амьсгалын тэргүүлэх чиглэлүүд болон ололт амжилтыг тодорхой мэдээлэх.

Оролцогч талуудын оролцоо: иргэний нийгэм, залуучууд, хувийн хэвшлийг “СОР17”-ийн бэлтгэл ажил болон үлдээх өвд багтаах.

Тогтвортой аялал жуулчлал нь уур амьсгалын зорилгуудыг дэмжиж, байгалийг хамгаалж, иргэдийг чадавхжуулахад чухал учраас хариуцлагатай аялал жуулчлал нь уг арга хэмжээний нэг гол сэдэв байх боломжтой. Дэлхийн өнцөг булан бүрээс олон мянган зочин төлөөлөгч ирэх учраас эко аялал жуулчлалын гол төв гэдгээ харуулах таатай боломж энэ удаад Монгол Улсад гарч ирж байна. Аялал жуулчлалын оновчтой зөв багцийг гаргаснаар гадаадын зочид танай улсын байгалийн болон соёлын баялаг өвийг өөрийн биеэр мэдрэх боломжтой болно. Үүнд бэлдэхийн тулд хуванцар хог хаягдлыг цэвэрлэх кампанит ажил, зам харгуйг засаж янзлах зэрэг ажлыг хийх ёстой болов уу. Мөн хогийн цэгийн зөв оновчтой менежмент нь салхиар хийсэж ирэх хог зэрэг бохирдлоос сэргийлэх, Монголын онгон дагшин байгалийг хамгаалахад тун чухал гэж бодож байна. ■



Шинэчлэл

БОНЗ-ын гэрчилгээтэй анхдагчдын нэг "Сүү" ХК

Байгаль орчин, Нийгэм, Засаглал буюу олон улсад ESG гэж нэрлэгддэг ойлголт нь байгууллагуудын хариуцлагатай, ил тод, тогтвортой байдлыг хэмжих чухал үзүүлэлт билээ. Тэгвэл “Сүү” ХК Миний монголын сүү, Элгэн тараг, Цөцгийн тос гэх гурван бүтээгдэхүүний савлагаан дээр тогтвортой байдлын баталгаажуулалтын тэмдэг болох ESG сертификатын логог байршуулах эрхийн гэрчилгээг 2025 оны 12-р сарын 09-ний өдөр гардан авсан юм. Европын Холбооны СВИЧ-Эйшиа хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Эдийн засгийн ногоон шилжилт” (Switching On the Green Economy- SOGE) төсөлд “Сүү” ХК хамрагдаж, дээрх гурван бүтээгдэхүүн дээр “Эко тэмдэгт”-ийн гэрчилгээг гардан авснаар Монгол Улсын хүнсний салбарын БОНЗ буюу ESG-ын гэрчилгээтэй анхдагчдын нэг болж байна.

Хөтөлбөрийг Пипл Ин Нийд ОУТББ (PIN), Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо ТББ (ТоС Холбоо), Хөгжлийн шийдэл ТББ болон Каритас Чех Репаблик ОУТББ (CCR) хамтран хэрэгжүүлсэн бөгөөд нийтдээ 340 гаруй төрлийн үнэлгээг хийж, шалгууруудыг хангаснаар бизнесийн үйл ажиллагааг илүү ногооруулах, тогтвортой хөгжлийн зорилтоо бататгах алхам болж буй. Түүнчлэн, гэрчилгээ нь зөвхөн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал төдийгүй

байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, эрчим хүчний үр ашиг, хог хаягдлын менежмент, нийгмийн хариуцлагын үзүүлэлтүүдийг цогцоор нь үнэлсэн олон улсын стандартад нийцсэн болохыг нотолж байгаа юм.



Д.Бямбажав: /“Сүү” ХК-ийн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал/ -Энэхүү төслийн хүрээнд хүнс үйлдвэрлэл ялангуяа хөдөө аж ахуйн салбартай холбоотой үйл ажиллагаа явуулдаг манайх шиг компанийн хувьд 2500 орчим малчин, бэлтгэн нийлүүлэгчтэй хамтран ажиллаж байна. Цэвэр органик сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа үйлдвэрлэгчийн хувьд бүтээгдэхүүнийг байгаль орчин, нийгмийн засаглалын хэм хэмжээний хүрээнд эрүүл, аюулгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагаа баталгаажуулж байгаа бас нэгэн том хувь нэмэр гэж ойлгож байна.



Б.Ариунболд: /“Сүү” ХК-ийн захиргаа хуулийн албаны дарга/ -“Сүү” ХК БОНЗ-ын менежментийн тогтолцоогоо хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлээд сертификатаа гардан авч байна. Манай компанийн үйлдвэрлэдэг Миний Монголын сүү, Элгэн тараг, Цөцгийн тос гэсэн гурван бүтээгдэхүүн дээр “Эко тэмдэгт”-ийн гэрчилгээг гардан авсандаа маш их баяртай байна. ▶

► Сүүлийн жилүүдэд дэлхий даяар хөрөнгө оруулагчид зөвхөн санхүүгийн ашиг олохоос гадна хөрөнгө оруулалтын байгаль орчин, нийгэм, засаглал (ESG – Environmental, Social, Governance)-д үзүүлэх нөлөөллийг чухалчилж үздэг болсон. ESG хөрөнгө оруулалт нь хүрээлэн буй орчин, нийгмийн сайн сайхан, тогтвортой хөгжилд анхаарал хандуулж, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргадаг хэн бүхний сонголт болсоор байна. ESG гэдэг нь байгаль орчин (Environmental), нийгэм (Social), засаглал (Governance) гэсэн гурван үгийн товчлол бөгөөд байгаль орчин, нийгэм, засаглалд эерэг нөлөөлөл үзүүлэх хөрөнгө оруулалт хийх хандлага, зарчмыг илэрхийлсэн үзүүлэлт юм. Эдгээр үзүүлэлтийг хөрөнгө оруулалтын шийдвэр болон үр дүнд дараах байдлаар үнэлж байна.

Байгаль орчин (Environmental) – Хөрөнгө оруулалтын байгаль орчинд үзүүлэх нөлөөг үнэлдэг. Үүнд, нүүрстөрөгчийн ялгарал, усны хэрэглээ, хог хаягдлын менежмент, сэргээгдэх эрчим хүч ашиглалт гэх мэт үзүүлэлтүүд багтдаг.

Нийгэм (Social) – Компаниудын нийгэмд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөллийг дүгнэдэг. Үүнд, ажилтнуудын эрх, хөдөлмөрийн аюулгүй байдал, хамт олны хөгжил зэрэг үзүүлэлтүүд ордог.

Засаглал (Governance) – Компанийн удирдлага, ил тод байдал, хуулийн зохицуулалт, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах зэрэгтэй холбоотой үзүүлэлтүүд багтдаг.

Яагаад ESG хөрөнгө оруулалт чухал вэ?

Санхүүгийн урт хугацааны тогтвортой байдал

ESG-ийн зарчмуудыг баримталдаг компаниуд урт хугацаанд илүү амжилттай ажиллаж, эрсдэлийг багасгах хандлагатай байдаг. Судалгаагаар ESG үзүүлэлт өндөр компанид хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчид илүү тогтвортой өгөөж хүртдэг нь багтагдсан.

Эрсдэлийн зөв менежмент

ESG хөрөнгө оруулалтууд нь байгаль орчинд ээлтэй, нийгэмд хариуцлагатай, засаглалын ил тод байдал сайтай компаниуд уруу чиглэдэг тул хууль эрх зүй, зах зээлийн савлагаанаас хамаарсан эрсдэлээ өөрийгөө хамгаалах чадвар сайтай байдаг.

Нийгэм, хүрээлэн буй орчинд үзүүлэх эерэг нөлөөлөл

Хөрөнгө оруулалт хийхдээ зөвхөн санхүүгийн өгөөжийг бус, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөг харгалзан үзэх нь ирээдүйн тогтвортой хөгжлийг дэмжихэд чухал үүрэгтэй.

Дэлхийн дахины чиг хандлага

Дэлхий даяар томоохон хөрөнгө оруулалтын сангууд ESG зарчмуудыг үйл ажиллагаандаа баримталж эхэлсэн. Хувийн хөрөнгө оруулагчдаас эхлээд томоохон корпорацууд ESG зарчимд нийцсэн хөрөнгө оруулалтыг илүүд үзэх хандлага давамгайлж байна.

Дэлхийд тавигдаж байгаа дээрх шалгуурыг

“Сүү” ХК давж, менежмент болон бүтээгдэхүүний түвшинд ногоон шилжилтийг бодитоор хэрэгжүүлсэн нь салбартаа шинэ жишиг тогтоосон, тогтвортой хөгжлийн бодлогоо тодорхой үйлдлээр баталгаажуулсан томоохон ололт болж байгаа юм.

“СҮҮ БОНД 2.0”



Монгол Улсын “ТОП-100” аж ахуйн нэгжийн нэг болох “Сүү” ХК найман жилийн дараа дахин бонд гаргах зөвшөөрөл авч, “Сүү 2.0” нэртэй бондыг 2025 оны есдүгээр сард гаргав.

Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим хамтран “ТОП-100 ААН-ийг хөрөнгийн зах зээлд татан оролцуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа. Энэ хөтөлбөрийн хүрээнд ялангуяа дотоодын бондын зах зээл дээр өрийн хэрэгсэл гаргах тохиолдолд тодорхой хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх нөхцөлийг журамд тусгаж өгсөн юм. Журмын дагуу ТОП-100 ААН ₮5 тэрбум хүртэлх үнийн дүнтэй нэг жилийн хугацаатай буюу олон улсад “Commercial paper” гэж нэрлэгддэг богино хугацааны санхүүжилтийн хэрэгслийг нээлттэй ►

▶ болон хаалттай хэлбэрээр гаргах боломжтой болсон. Хэрэв нээлттэй хэлбэрээр бонд гаргавал барьцаа, баталгаагүйгээр гаргах бөгөөд СЗХ шийдвэрийг нь 1-10 хоногийн дотор хурдан гаргахаар зохицуулж өгсөн. Ингэснээр цаг хугацаа, өртгийг асар их бууруулж байгаа гэдгийг мэргэжилтнүүд онцолж буй.

ТОП-100 аж ахуйн нэгж хөрөнгийн зах зээлд барьцаа, батлан даалт шаардахгүй 5 тэрбум төгрөг хүртэлх бондыг олон нийтэд санал болгох боломжтой болсноос хойш Монгол Улсын ууган үйлдвэр “Сүү” ХК анхны бондыг гаргахаар эрхээ авсан нь энэ юм. “Сүү 2.0” бонд нь 12 сарын хугацаатай бөгөөд нэгжийн нэрлэсэн үнэ нь 100 мянган төгрөгөөр тогтоогдсон. Мөн жилийн 17 хувийн хүүтэйгээр зах зээлд гарч буй нь арилжааны банкны хадгаламж болон бусад өрийн хэрэгслээс дунджаар 4.8 хувиар өндөр өгөөжтэй байгаа нь хөрөнгө оруулагчдад онцгой давуу талыг бий болгож буй.

“Сүү” ХК-ийн хувьд өмнө нь 2017 онд Монголын хөрөнгийн биржээр дамжуулан “Сүү бонд”-ыг олон нийтэд нээлттэй арилжаалж, нийт зургаан тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татаж байсан. Тухайн үед жилийн 17.5 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатай байсан энэхүү бонд нь өндөр эрэлтгүйгээр зах зээлд бүрэн борлогдож, хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн нь компанийн өрийн хэрэгсэл амжилттай арилжигдаж болохыг харуулсан түүхэн жишээ болж үлдсэн билээ.

“Сүү 2.0” бонд цан цохих ёслолын үеэр “Сүү” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Гантулга “Сүү хувьцаат компани 67 жилийн турш хэрэглэгч харилцагч нартаа чанартай, баталгаатай, найдвартай хүнсийг үйлдвэрлэж, нийлүүлсээр ирсэн. Монгол Улсын ууган хувьцаат компаниудын нэг. Өдгөө 200 тэрбум төгрөгийн зах зээлийн ханштайгаар үйл ажиллагаа явуулж байна. “Сүү” хувьцаат компани 2017 онд хамгийн өндөр үнэтэй бондыг хөрөнгийн зах зээл дээр танилцуулж байсан. Тухайн үед гурван өдрийн дотор 6.8 тэрбум төгрөгийн захиалга авч хааж байлаа. “Сүү” бондын тухайн үед гаргаж байсан үр дүн нь юу вэ гэхээр бид “булган сүүл”-тэй байж, хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлж өгсөн” хэмээсэн юм.

Ард түмний хүнс “Шимт сүү”, “Хорхой ааруул”

Монголын хүнсний салбарын нэр хүндтэй шалгаруулалт болох “Ард түмний хүнс-2026”-гаар Сүү ХК-ийн хоёр бүтээгдэхүүн зэрэг тодорсон юм. Хэрэглэгчдийн санал, салбарын шинжээчдийн үнэлгээгээр “Шимт сүү”, “Миний Монголын Хорхой Ааруул” нь “Ард түмний хүнс-2026” хэмээх эрхэм өргөмжлөлийг хүртэж, хэрэглэгчдийн сонголтыг дахин нэг удаа баталгаажуулав.

Энэ удаагийн шалгаруулалтад үндэсний томоохон үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд өрсөлдсөнөөс “Сүү” ХК-ийн бүтээгдэхүүнүүд хамгийн өндөр оноогоор тэргүүлж, монголчуудын өдөр бүрийн амьдралын салшгүй хэсэг болсон сүү, ааруул “АРД ТҮМНИЙ ХҮНС” гэх шинэхэн хуудсаа нэмлээ. ▶





► “Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал

Б.Гантулга:

“Сүү” ХК-ийн үйлдвэрлэдэг “Миний Монголын сүү”, “Аморе зайрмаг”, “Элгэн тараг” зэрэг бүтээгдэхүүн “Ард түмний хүнс” шагналыг авсан байдаг. Энэ жилийн тухайд “Миний Монголын Хорхой Ааруул” маань уг шагналыг авч байгаад туйлын баяртай байна. Хорхой ааруул нь “Сүү” ХК-ийн 67 жилийн түүхэнд хамгийн урт, удаан хугацаанд үйлдвэрлэгдэж байгаа бүтээгдэхүүнүүдийн нэг гэдгээрээ онцлог.

Ер нь, гаднын зочид, төлөөлөгчдийг угтах үйл ажиллагааны мөнгөн аяганд байдаг бүтээгдэхүүн бол манай хорхой ааруул. Японы Эзэн хаан манай улсад анх удаа айлчлахдаа түүхэндээ анх удаа олны дунд юм идэж, тэр нь манай хорхой ааруулыг идсэн. Манай “Миний Монголын Хорхой” ааруулын талаар Япон улсын хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчид тусгай нэвтрүүлэг бэлтгэсэн. “Миний Монголын Хорхой Ааруул”, “Шимт сүү” гэсэн хоёр бүтээгдэхүүн “Ард түмний хүнс-2026”-гаар тодорлоо. Үндэсний ууган үйлдвэртэй үргэлж хамт байж, үндэсний үйлдвэрлэлээ дэмждэг хэрэглэгч олон нийтдээ гүнээ талархал илэрхийлье.

Монгол Улсын ууган үйлдвэр Сүү ХК нь тетрапак савлагаатай Шимт сүүгээрээ Ард түмний хүнсээр шалгарсан. Тетрапак савлагаатай сүү нь хөдөө аж ахуйгаас бэлтгэж байгаа саалийн сүүг асетик технологиор савлаад ард түмэнд хүргэж буй хүнсний бүтээгдэхүүн. Энэ бүтээгдэхүүн хэрэглэгчдийн таашаалд нийцсэн чанартай бүтээгдэхүүн болсонд маш их баяртай байна.

“Шимт сүү” нь эрүүл мэндийн ач холбогдлыг хадгалсан, хүн бүрийн хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн гэдгээрээ хэрэглэгчдийн итгэлийг олсон бол “Миний Монголын Хорхой ааруул” нь шим тэжээл, зөөлөн амт, чанар стандартаараа онцгой билээ. Эдгээр бүтээгдэхүүн нэг жилд хоёул “Ард түмний хүнс” хэмээн өргөмжлөгдсөн нь “Сүү” ХК-ийн чанар, стандарт, бодлого тогтвортой,

зохистойгоор хэрэгжиж, хэрэглэгчдийн үнэлэмж өндөр байгаагийн баталгаа юм.

Үндэсний үйлдвэрлэгч “Сүү” ХК дахин “ТОП-100 аж ахуйн нэгж” жагсаалтад багтлаа

Хүнсний салбарын манлайлагч “СҮҮ” хувьцаат компани “ТОП-100 аж ахуйн нэгж”-ийн жагсаалтад 56 дугаар байрт эрэмбэлэгдэж, эх орныхоо эдийн засаг, эрүүл хүнсний хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буйгаа дахин батлан харууллаа.

Жилийн орлого, улсын төсөвт оруулсан татвар, нийгмийн даатгал төлсөн ажиллагсдын тоо, ашиг, хөрөнгийн хэмжээ зэрэг үндсэн шалгуураар үнэлэгддэг энэхүү жагсаалтад үндэсний ууган үйлдвэр “Сүү” ХК жил бүр тогтвортой, найдвартайгаар урагшилсаар байгаа билээ. Энэ жилийн тухайд нийтдээ 14 байраар урагшилж, үсрэнгүй амжилтыг гаргаад байна.

”Сүү” ХК-тай 67 жилийн турш хамт байсан үнэнч хэрэглэгчдийн итгэл энэхүү амжилттай салшгүй холбоотой билээ.

Монгол Улсын үндэсний ууган үйлдвэр болох “Сүү” ХК-ийн хувьд цаашид нийгэм, эдийн засаг, хүнсний үйлдвэрлэл, эрүүл мэндийн салбарт тогтвортой хувь нэмрээ оруулан, Улаанбаатар хот, 21 аймаг, 330 сумдад эрүүл, аюулгүй, чанар стандартын шаардлагыг хангасан сүү, сүүн бүтээгдэхүүнийг өглөө бүр шинэхнээр үйлдвэрлэн ханган ажиллаж байна.



Сүү ХК нь гагцхүү сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд зогсохгүй ард иргэд, хэрэглэгч олны эрүүл энх, энх тунх аж төрөх их үйлсэд хувь нэмрээ үзүүлэн уламжлалт сүү, сүүн бүтээгдэхүүний соёлыг шинэ үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ажиллаж байна. ■



Сурвалжлага

Хар тэнгисийн эрэг дээрх **МОНГОЛ** залуусын цугларалт

Эх газрын эл тэнгис зөөлөн давалгаална. Гүн цэнхэр тэнгэр дэх наран авхайн алтан цацраг их далайн ус руу шууд бууж байгалийг улам үзэсгэлэн төгс болгох аж. Хязгаар нь үл харагдах их далайд хааяа нэгхэн усан онгоц хөвж харагдана. Тэд хэдэн зууны тэртээгээс энэ л усан замаар нэг чанадаас нөгөө рүү хөвж мөс зүссэн онгоцуудын үргэлжлэл. Ази, Европыг холбосон энэ тэнгис далай хэдэн хүнийг тэжээж, хэдэн улсын эдийн засгийг хүчирхэгжүүлж, хэдэн зууны түүхийг өгүүлэн ирсэн бол. Хар тэнгис нь ачаа тээврийн чухал зангилаа бүс нутаг, мөн стратегийн болон цэргийн ач холбогдолтой тэнгис.

Найман зуун жилийн дараа тэдний үр сад болсон монгол залуус дэлхийн дөрвөн тивээс төмөр хүлгээр нисэн ирэв

Тийм учраас дэлхийн талыг эзэлж, Их Монгол Улсаа байгуулж явсан монголчуудын түүх ч энэ л хар тэнгистэй холбогддог юм. Найман зууны тэртээ Монголын залуус морин дэл дээр давхиж ирж Дундад Азийг байлдан дагуулж, эзэлж, улмаар Чингис хааны ач хүү Хүлэгү хан Ил хаант улсыг байгуулсан нь 100 гаруй жил оршин тогтносон байдаг. Эл түүхээр Монголын залуус үргэлж бахархаж байх учиртай.

Тэртээ XIII зуунд монгол залуус хар далайн эрэг дээр морьтойгоон ирж, чанадын чанадын цаана буй эх орноо санагалзан суусан тэр л газарт найман зуун жилийн дараа тэдний үр сад ►

► болсон монгол залуус дэлхийн дөрвөн тивээс төмөр хүлгээр нисэн ирэв. Өвөг дээдсийнхээ тамгалсан Турк улсад ОХУ, Хятад, Англи, Герман, Казахстан, Австрали, Австри, БНСУ зэрэг 24 орны 250 орчим монгол оюутан залуучууд чуулсан нь Ковидоос хойших хилийн чанад дахь монгол оюутан залуусын хамгийн том цугларалт болсныг тэмдэглэе.

Анхны чуулга уулзалтыг Улаанбаатар хотноо Төрийн ордонд 550 гаруй оюутан залуусын оролцоотойгоор зохион байгуулж байсан. Түүнээс хойш ОХУ, Япон, Хятад, Өмнөд Солонгос, хамгийн сүүлд 2019 онд Унгар улсад зохион байгуулсан. Зургадугаар чуулга уулзалтыг БНТУ-д хийхээр төлөвлөсөн байсан ч дэлхий дахинаа Ковид цар тахал гарснаар хойшлогдсон юм. Ингээд зургаан жилийн дараа энэхүү арга хэмжээг Туркийн Истанбул хотноо амжилттай зохион байгууллаа.

Хилийн чанад дахь монголчуудын зөвлөл болон зөвлөлийн Оюутан залуусын хорооноос зохион байгуулсан уг чуулга уулзалт Хар тэнгисийн эрэг дээрх Мармара амралтын газарт болсон билээ. Залуус гурван өдрийн турш хамтдаа байж, танилцаж, нөхөрлөж, эрхэм зорилгоо ярилцахын сацуу, монгол өв соёл, монгол хүн байхын утга учир, дэлхийн хүн болохын алхам, эх орны хөгжлийн ирээдүйн бодлого, эх нутаг, гэртээ харих зам зэрэг сэдвээр илтгэл сонсч, ярилцаж, санал бодлоо хуваалцаж, хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

Мөн залуусын дунд NextGen төслийн уралдаан зарлаж, шилдэг төслүүдийг чуулга уулзалтын үеэр шалгарууллаа. Уг уралдаанд 19 төсөл ирснээс 9 төслийг хоёр дахь шатанд үлдээж, чуулга уулзалтын үеэр төслөө танилцуулах боломжийг оюутнуудад олгосноор гурван төсөл шилдгээр шалгарсан болно. Нэгдүгээр байранд, Унгар улсын Ectvcs Lorбnd, Ubu-da University их сургуулиудын оюутан Б.Ган-Эрдэнэ, Г.Шагдарсүрэн, Д.Түмэндэмбэрэл нарын “EduLink Mongolia” төсөл шалгарлаа. Хоёрдугаар байранд Турк улсын Истанбулийн Их сургуулийн оюутан Т.Энхтөрийн “Khuvaaltsay” төсөл орсон бол гуравдугаар байранд ОХУ-ын Москвагийн Эрчим хүчний сургуулийн оюутан Ц.Цэцгээгийн “Яндангүй гэр” төсөл тус тус орж мөнгөн шагнал гардсан.

Залуус төслийн санаагаа маш их бодож,

Мөн залуусын дунд Next-Gen төслийн уралдаан зарлаж, шилдэг төслүүдийг чуулга уулзалтын үеэр шалгарууллаа.

улс орныхоо хөгжлийн асуудлуудыг шийдэхэд чиглүүлсэн байлаа. Тухайлбал, EduLink Mongolia төслөөр эцэг эхчүүдэд тулгардаг хүүхдүүдийн гэрийн даалгавар хийх асуудлыг, “Яндангүй гэр” төслөөр нийслэлийн утааны асуудлыг, ногоон төслүүдээр уур амьсгалын нөлөөллөөр учирч буй байгаль орчны асуудлуудыг шийдэхийг эрмэлзсэн байв.

Энэхүү арга хэмжээг БНТУ-ын Залуучууд, спортын яам, Монгол Улсын ЭСЯ, Консулын газар дэмжиж, Турк, Монголын сан санхүүгийн ивээн тэтгэлэг үзүүлсэн байна. Тус арга хэмжээний нээлтэд, Хилийн чанад дахь Монголчуудын Зөвлөлийн тэргүүн С.Цэрэндэмбэрэл, Монгол Улсаас БНТУ-ын Истанбул хотноо суугаа Ерөнхий Консул, Др (PhD) Д.Анхбаяр, БНТУ-ын Залуучууд, спортын яамны дэд сайд Enes Eminoglu, Турк-Монгол Сангийн Ерөнхийлөгч Veysel Citfci, Профессор доктор Ахмет Ташағыл, Шударга Намын (AK Parti) Истанбул мужийн дэд дарга Профессор доктор Сүлейман Каан Ялчын, хуульч Исмаил Байрак Осман Башер нар оролцож үг хэлсэн. Эдгээр хүмүүсийн хэлсэн үгийн агуулга эртний түүхээр холбогддог Монгол Улсын залуус БНТУ-д ирж чуулж байгаад талархаж буйгаа илэрхийлж байлаа. Энэхүү арга хэмжээг Турк, Монголын сан санхүүгээр 100 хувь ивээн тэтгэсэн юм. Турк-Монгол Сангийн Ерөнхийлөгч Veysel Citfci “Европ, Ази тивийг холбосон гайхамшигт Истанбул хотноо энэхүү арга хэмжээг зохион байгуулж байгаадаа бид баяртай байна. Турк-Монгол сангийн хувьд хоёр орны ард түмний дунд найрамдал, харилцан ойлголцлын гүүр болж, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорьдог” хэмээн ярьсан юм.

“Турк улсыг сонгосон гол шалтгаан нь оюутнууд маань өргөнөөр оролцох боломжтой гэж үзсэн. Визийн хязгаарлалтгүй улс. Мөн газарзүйн байршил, тээвэр, ложистикийн хувьд Европ, Азийг холбосон улс. Түүнчлэн ХЧМЗ-ийн томоохон баг ажилладаг, энэ бүхэн нь Истанбул хотыг сонгоход хүргэсэн гэж хэлж болно. Манай зөвлөл 2025 оны төлөвлөгөөндөө оруулж, бүтэн нэг жил орчим бэлдэж ажилласны үр дүнд монгол оюутан, залуусын маань чуулга уулзалт амжилттай боллоо. Зургадугаар уулзалтад ирсэн оюутнуудын 70 гаруй хувь нь техник технологи, нарийн мэргэжлээр сурч буй оюутнууд байсан нь ►



ИЙН ЧАНАД ДАХЬ МОНГОЛ ОЮУТАН, ЗАЛУУЧУУДЫН ЧУУЛГА УУЛЗА



► энэ удаагийн арга хэмжээний бас нэгэн онцлог байлаа. Гол зорилго оюутан залуусыгаа хооронд нь уулзуулах, танилцуулах, холбоо харилцааг бий болгох, мэдлэг туршлага хуваалцах, урам өгөхөд мөн тэднийг оролцоог нийгмийн хөгжилд татан оролцуулах явдал байв. Энэ жил бид оюутан, залуучууд гэж чуулга уулзалтын цар хүрээг тэлж өгсөн. Зөвхөн оюутнууд төдийгүй хилийн чанадад ажиллаж амьдарч буй залуусыг оролцуулснаараа энэ удаагийн арга хэмжээ онцлог боллоо хэмээн Хилийн чанад дахь монголчуудын зөвлөлийн тэргүүн С.Цэрэндэмбэрэл онцлов.

Гадаадад сурч буй оюутан залуусыг 3-4 бүлэгт хувааж болно. **Нэг**, Монголдоо сургуулиа төгсөөд гадаадын улс орнуудад очиж суралцаж буй оюутнууд. **Хоёр**, хувиараа, мөн төрийн сан, тухайлбал, Ерөнхийлөгчийн илгээлтээр сурч буй бүлэг. **Гурав**, аав ээж нь 20,30 жилийн өмнө тухайн улс оронд очиж ажиллаж амьдарсан

Монгол хүн, эх орны тухай итгэл үнэмшлийг нь улам бэхжүүлэхэд чуулганы илтгэлүүдийн агуулга чиглэсэн

бүлэг оюутан залуус байна. **Дөрөв**. Эх орондоо сургуулиа төгсөөд гадны улс оронд бакалавр, магистраа хамгаалаад тухайн улсад мэргэжлээрээ амжилттай ажиллаж буй нэг хэсэг бүлэг байна. Энэ бүлэг залуусын оролцоог уг чуулга уулзалтаар хангаж өгснөөрөө Истанбулын арга хэмжээ их ач холбогдолтой болсон гэдгийг ХЧМЗ-ийн тэргүүн тодотгож өгөв.

Чуулганы үндсэн сэдэв “Дэлхийд хүрэх монгол оюун”. Энэ утгаар залуусд монгол хүн байхын утга учир, монгол хүн болж төрсний онцлог давуу тал, Монгол Улсынхаа түүх соёл, уламжлал, үндэсний онцлогийн талаар тодорхой ойлголт мэдээлэл өгөхийг хүсчээ. Монгол хүн, эх орны тухай итгэл үнэмшлийг нь улам бэхжүүлэхэд чуулганы илтгэлүүдийн агуулга чиглэсэн. Судлаач, доктор Ё.Отгонбаяр “Монгол хүн байхын утга учир” илтгэл, Монгол адууны диваажин хөтөлбөрийг санаачлагч Б.Наранбадрах монгол

▶ адуу, монгол соёл өв соёл болон “Хүний энэрэнгүй сэтгэл” сэдвээр илтгэл тавьсан бол Их Британийн Лондон Соут Банк их сургуулийн бизнесийн сургуулийн ахлах багш, МВА хөтөлбөрийн захирал Х.Саранзаяа “Өөрсдийн үнэт зүйлс, онцлогт тулгуурлан дэлхийн иргэд болох нь” илтгэлээрээ даяаршсан нүүдэлчин шинэ үеийн монгол залуус дэлхийд ямар үнэт зүйл, хувь нэмэр авчрах болон монгол онцлогтой маркетингаар дэлхийн зах зээлд гарах боломжийн тухай ярилаа.

Монголын оюун ухааны академийн ерөнхийлөгч, Монгол Улсын гавьяат багш Х.Хатанбаатар “Хурдтай суралцах чадвар”, илтгэлээрээ шинэ орчинд амжилттай суралцах, өөрийн чадавхийг хөгжүүлэх, суралцах ур чадварын цогц ойлголт бүхий илтгэл оюутан залуучуудын сонирхлыг ихэд татлаа.

Mongolian Economy сэтгүүлийн Ерөнхий Эрхлэгч, сэтгүүлч Д.Бэхбаяр “Монгол залуусын ирээдүйн боломж ба сорилт” илтгэлээрээ Монгол Улсын ойрын болон ирээдүйн хөгжлийн үзэл баримтлал бодлогын талаар товч танилцуулж, түүнд залуусын боломж, оролцоо хир байх, шинэ үеийн залуусыг ямар хөгжлийн бодлоготой улс орон хүлээж байх, эрсдэл нь юу байх талаар бодит мэдээлэл өглөө.

SKS LLC-Deed motors, Japanshop.mn үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал А.Долгион “Гэртээ харих зам - Гэрэл ба давс болохын үнэ цэнэ” илтгэлээр дамжуулан гадаадад сурч байх хугацаандаа бусдын төлөө сайн дурын ажил

Тэд эх орны итгэл найдвар, энгүй их оюуны хүчтэй залуус

хийхийн үнэ цэн, гэртээ харих замаа тодорхойлон эх орондоо буцан ирэх шийдвэрийн хүч, Монголдоо хэрхэн очих, эргэж очоод ажиллаж амьдрахад тулгардаг асуудлууд гарц шийдлийн талаар өөрийн бодитой жишээнд тулгуурлан ярьсан нь залуусын урам зоригийг сэргээж өглөө.

Чуулга уулзалтын үеэр залуус хоорондоо хилийн чанадад суралцахын давуу болон сул тал, боломжуудын талаар ярилцаж, мэдлэг туршлагаа хуваалцаж, мөн спортын төрлүүдээр уралдаж, тоглоон наадаж, Истанбул хотын түүхэн дурсгалт газруудаар аялж, мартагдашгүй дурсамж бүтээсэн өдрүүдийг үдсэн.

Ийн эх орон, элэгт нэгтэн монгол залуус нэг дор цуглаж, хөгжилдөж, инээд хөөр, хайр дүүрэн хугацааг хамтдаа өнгөрөөж, сэтгэл дүүрэн баяртайгаар элэг зүрхэндээ эх орноо хөгжүүлэх чин сэтгэл өвөрлөн хээрийн галуу нисэн үл хүрэх дөрвөн тивийн 24 улс руу хөгжлийн зам татуулан нисцгээсэн. Тэд Монгол Улсын ирээдүй, тэд эх орны шинэ хөгжлийг бүтээх залуус, тэд улсаа дэлхийд дахин тамгалах манлайлагчид, тэд хөгжлийг түүчээлэх шилдэг боловсон хүчнүүд, тэд эх орны итгэл найдвар, энгүй их оюуны хүчтэй залуус.

Тэд ихийг сурч, боловсроод, дэлхийн хүмүүс болж төлөвшөөд, олон улсын өргөн боломжуудыг харж ашиглаж мэдсэнийхээ дараа эх нутгаан зорьж, гэртээ ирнэ гэдэгт би итгэж байна. ■

Д.Бэхбаяр Турк. Истанбул хот. 2025.11.08



Санхүүгийн боловсрол



GENTOO LAWYERS
YOUR FAMILY & IMMIGRATION SPECIALISTS

ANNA NGUYEN: Бид Австралид амжилттай, найдвартай ирээдүй рүү хөтлөхөд үргэлж бэлэн байх болно

Австрали улсын Gentoo Lawyers хуулийн фирмийн хуульч Anna Nguyen-тэй ярилцлаа. Gentoo Lawyers нь Монголын Kangaroo agency-гийн Австрали улс дахь албан ёсны түнш юм.

-Та Монгол Улсад удахгүй ирж, Австрали улсын цагаачлалын хуультай холбоотой хурал семинарт оролцох гэж байна. Монгол Улсын талаарх сэтгэгдлээсээ эхлээд хуваалцана уу?

-Монгол Улсад анх удаа ирж байгаадаа маш их баяртай байна. Сүүлийн жилүүдэд би олон монгол найз, харилцагч, оюутнуудтай Австралид танилцаж, тэдний халуун дулаан сэтгэл, гэсвэр тэвчээр, эх оронч, гэр бүлсэг зан чанарыг бишрэн хүндэлж ирсэн. Монгол бол өвөрмөц соёлтой, хурдацтай хөгжиж буй улс.

Танай улсад зочилж, Австралийн хууль эрх зүй, боловсрол, хөрөнгө оруулалтын орчныг ойлгох хүсэлтэй хүмүүстэй уулзах гэж байгаадаа сэтгэл их хөдөлж байна. Монголчуудад мэдлэгээ хуваалцаж, гэдэнтэй нүүр тулан уулзах боломжийг олгож буй хуралд оролцож байгаа нь миний хувьд тун хүндтэй хэрэг юм.

-Та хуулийн фирмээ манай уншигчдад товч танилцуулна уу?

-ANNA & CO LAWYERS T/A GENTOO LAWYERS бол цагаачлал, гэр бүл, өв залгамжлал, үл хөдлөх хөрөнгө, бизнес болон худалдаа, иргэний болон эрүүгийн хууль, хүний эрх, нотариатын үйлчилгээ зэрэг чиглэлээр хуулийн цогц үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм. Бид захиргааны хэргийн маргаан, виз болон иргэний харьяаллын асуудал, гэр бүл салалт, хүүхдийн асран хамгаалал, үл хөдлөх

Австрали улсад хувь нэмрээ оруулах хүсэлтэй оюутнуудыг дэмжинэ



хөрөнгийн маргаан, өв залгамжлал, гэрээслэл, бизнесийн хэлцэл, лизинг, өр барагдуулах, үл хөдлөх хөрөнгө эзэмших эрхийн шилжүүлэг зэрэг үйлчилгээ мөн үзүүлдэг.

Манай фирм олон улсын харилцагч нартай нягт хамтран ажилладаг олон соёлыг агуулснаараа бусад фирмээс ялгардаг гэж болно. Манай ажилтнууд англи, монгол, орос, вьетнам, хятад, испани, португал, энэтхэг, балба зэрэг олон хэлээр үйлчилгээ үзүүлэх чадвартай.

Манай фирм цогц, ил тод, практик, үр дүнд чиглэсэн хуулийн шийдэл гаргахад анхаарч ажилладаг. Визний материал бүрдүүлэлт, компани худалдаж авах, гэр бүлийн асуудал, үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын аль нь байхаас үл хамаарч бид хэрэглэгч тус бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцэхүйц стратегитай, чин сэтгэлийн, мэргэжлийн тусламж зөвлөгөөг үзүүлсээр ирлээ.

-Австрали улсад монголчууд олноороо оршин сууж, амьдардаг, мөн олон оюутан сурдаг. Тиймээс монголчуудад Австрали улсын хуулийн мэдлэг маш чухал. Gentoo Lawyers, Монголын Kangaroo agency-гийн хамтын түншлэл ямар асуудалд голлон чиглэх вэ?

-Австралид ажиллаж, амьдарч буй монголчуудын тоо тогтмол өсөж, өөрсдийн хууль ёсны эрх, боломжуудыг ойлгохыг хүсдэг болсон учраас бидний хувьд Монгол бол ▶

▶ анхаарал хандуулдаг чухал улс юм. Kangaroo Agency байгууллагатай хамтран ажиллах замаар бид зөвхөн монгол харилцагч наргаа зориулсан цагаачлалын зөвлөх үйлчилгээ, визтэй холбоотой алдаанаас сэргийлэх, виз гарах боломжийг нэмэгдүүлэх тухай сургалт семинар явуулах, комплаенс, ажиллах эрх, цагаачлах арга замын талаар гадаадын оюутнуудад дэмжлэг тусламж үзүүлэх, Австралид компани байгуулах, үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулахад туслахыг зорин ажиллаж байна.

Маш олон монгол хүн Австралийг суралцах, цагаачлах, урт хугацаагаар ажиллаж амьдрах улсаараа сонгох болжээ. Бид тэрхүү аяллыг нь итгэл даах хууль эрх зүйн зөвлөгөөгөөр дэмжиж ажиллах болно.

-Австрали улс дахь манай улсын иргэд, оюутнуудад ямар асуудал түлхүү тулгарч, хүндрэл үүсгэдэг вэ?

-Дараах түгээмэл асуудлууд байдаг гэж үзэж болно. Ажиллах эрхийн хязгаар, сургалтын шаардлага зэрэг визийн нөхцөлүүдээ буруу ойлгох, виз сунгуулах, эсвэл Оюутны визэнд тавигдах шаардлагад хүндрэл гарах, асуудал гарах үед найдвартай хууль эрхзүйн үйлчилгээ авах боломж бололцоо дутмаг байх, Австралийн ажлын байртай холбоотой хууль дүрэм журмыг сайн мэдэхгүйгээгээс үүдэж ажилд ороход төрөл бүрийн сорилттой тулгарах, байр, түрээс зэрэг үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудлууд болон хэлний бэрхшээлээс үүдэн төрийн байгууллага, их сургууль, ажил олгогчтой үл ойлголцох зэрэг бэрхшээл бий.

Монгол оюутан, гэр бүлийг анхнаас нь зөв мэдээллээр хангах, ингэснээр хуулийн төрөл бүрийн асуудлаас зайлсхийх, Австралид ирээдүйн амьдралаа бүтээхэд голлон анхаарахад нь туслах бол манай байгууллагын зорилго юм.

-Австрали улсын чанартай боловсролын систем нь дэлхийд дээгүүрт ордог. Тиймээс манай залуус танай улсад сурахыг хүсдэг. Гэхдээ визний нөхцөл чанга гэж хардаг. Оюутны визийн боломж, хөнгөлөлт, сурахын хажуугаар ажиллах хуулийн нөхцөлүүдийн талаар та тодорхой ярьж өгнө үү?

-Австрали улс гадаадын оюутнуудад сурах нэн таатай боломжуудыг санал болгодог. Виз олгох процесс тодорхой дүрэм журамтай ч сайн бэлдэж чадвал виз гарах бүрэн боломжтой. Энэ тал дээр анхаарах гол асуудлууд бол:

- **Суралцах боломж:** 1,000 гаруй сургууль, боловсролын байгууллага дэлхийн түвшний чанартай сургалтыг санал болгодог.
- **Тэтгэлэг:** Манай фирм болон Kangaroo Agency зэрэг хамтрагч байгууллагаар дамжуулан маш олон коллеж, их сургуулиуд монгол

оюутнуудад тэтгэлэг, төлбөрөө хэсэгчилж төлөх, хямдрал зэргийг санал болгодог.

- **Ажиллах эрх:** Оюутны визтэй суралцагчид суралцах хугацаандаа хоёр долоо хоногт 48 цаг, харин албан ёсны амралтаар хугацаагүй ажиллах эрхтэй.
- **Төгсөлтийн дараах боломжууд:** Маш олон төгсөгч Temporary Graduate ангиллын виз (Subclass 485) мэдүүлэх эрхтэй болдог бөгөөд ингэснээр мэргэжилтэй ажилтны цагаачлах эрх үүсэх боломжтой юм.

Ерөнхийдөө уг систем нь суралцах, туршлага хуримтлуулах, Австрали улсад хувь нэмрээ оруулах хүсэлтэй оюутнуудыг дэмжихэд чиглэсэн юм.

-Австрали улсын цагаачлалын хуулийн гол заалт, онцлог нь юу вэ?

-Австралийн цагаачлалын систем нь дараах үндсэн зарчмуудад тулгуурладаг:

- *Merit суурьтай, ур чадварт төвлөрсөн сонгон шалгаруулалт*
- *Хөтөлбөрийн нэгдмэл байдлыг хадгалах зорилготой хатуу чанд боловч шударга комплаенсын систем*
- *Оюутан, ур чадвартай цагаач, хөрөнгө оруулагч, гэр бүл зэрэг ялгаатай бүлгүүдэд зориулсан визний маш тодорхой дэд төрлүүдтэй*
- *Хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөгдөн буй эрэлт хэрэгцээнд нийцүүлсэн бодлогын байнгын шинэчлэл*
- *Визтэй хүмүүсийг хамгаалах, ингэснээр шударга, эрх тэгш байдлыг хангах*

Хэдий нарийн төвөгтэй, цогц боловч уг систем нь шаардлага хангасан хүн бүрийн хувьд ил тод, тодорхой бүтэцтэй байдаг юм.

-Австрали улсад үл хөдлөх хөрөнгө худалдан авснаар ямар эерэг боломж нөхцөлүүд үүсдэг вэ?

-Австралид үл хөдлөх хөрөнгө худалдаж авах нь хэд хэдэн давуу талтай. Тухайлбал, хөрөнгө эзэмших эрх, гэрээний системээр дамжуулж худалдан авагчдыг хуулийн хамгаалалтаар хангаж чаддаг. Урт хугацаандаа өсөлт үзүүлэх үл хөдлөх хөрөнгийн тогтвортой зах зээлтэй, томоохон хотуудад түрээсээр дамжуулж орлого олох, бизнесийн болон хөрөнгө оруулалтын нэр хүндээ нэмэгдүүлэх, Австралид урт хугацаанд амьдарч буй гэр бүл, оюутнуудад тогтвортой байдал үүсэх зэрэг багтана.

Үл хөдлөх хөрөнгө худалдаж авах нь визтэй болох багалгаа болохгүй ч санхүүгийн болон практик утгаараа маш давуу талтай. Энэ нь ялангуяа Австралид ▶



Австралид компани байгуулах, үл хөдлөх хөрөнгө оруулахад туслахыг зорин ажиллаж байна

► амьдрах, эсвэл хөрөнгө оруулах хүсэлтэй гэр бүлүүдэд тун чухал.

-Мөн Австрали улсад хөрөнгө оруулалт хийснээр визний, хуулийн ямар боломжуудыг монголчууд эдлэх эрх үүсэх талаар тодруулж ярина уу?

-Эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, бизнес эхлүүлэх, хөрөнгө оруулах хүсэлтэй иргэдэд Австрали улс олон төрлийн боломжийг санал болгож чаддаг. Хууль эрхзүйн систем нь тогтвортой, дүрэм журам нь ил тод учраас буурь суурьтай хөрөнгө оруулагчдыг соронз мэт тагддаг.

Бизнес үүсгэн байгуулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, томоохон хөрөнгө оруулалтад хамтрах хүсэлтэй монгол хөрөнгө оруулагчдын хувьд Австралид ажиллаж, амьдрах эрх үүсэх, бизнесээ томруулахад нь туслах маш олон төрлийн боломж бий.

Хамгийн гол нь бодитой бизнес үйл ажиллагаа, санхүүгийн боломж, орон нутгийн эдийн засагт хувь нэмрээ оруулах хүсэлтэй байх хэрэгтэй. Хууль эрхзүйн сайн төлөвлөгөө гаргаж чадвал Монголын хөрөнгө оруулагчид хууль ёсны, урт хугацааны боломжуудыг эрэлхийлж болно.

-Гадаадын хөрөнгө оруулагчдад Австрали улсын үзүүлдэг хууль эрх зүйн орчны талаар сонирхуулна уу? Учир нь манай улс ГХО-ын

тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-аар 2026 онд батлуулахаар ажиллаж байна. Тиймээс танаас энэ талын мэдээлэл авах гэсэн юм.

-Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан хамгийн аюулгүй, ил тод хуулийн орчинтой улсуудын нэг гэдгээрээ Австрали алдартай. Энэ тал дээр гол давуу тал, онцлогуудыг дурдъя:

- Хуулийн засаглал болон бие даасан шүүх
- Татвар болон аж ахуйн нэгжийн маш тодорхой хууль дүрэм журам
- Хөрөнгө өмчлөх эрхийг сайн хамгаалдаг
- Үндэсний эрх ашгийн хүрээнд гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдад эрх тэгш ханддаг
- Хүчирхэг, тогтвортой банкны систем
- Урьдчилан таамаглаж болох хууль эрхзүйн систем

Ил тод, урьдчилан таамаглаж болох, хүчирхэг хуулийн институт нь хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлдэг гэдгийг Австралийн жишээ харуулдаг. Монгол Улсын хувьд ч энэ чиглэлийн хууль эрхзүйн шинэчлэл нь дээрхтэй ижил зарчмуудыг хэрэгжүүлэх, үүнийгээ улс орны эдийн засгийн зорилгуудад нийцүүлэх сайхан боломж болно гэдэгт итгэлтэй байна.

-Та Австрали улс руу ажиллах, эсвэл сурахыг сонирхож буй хүмүүст юу гэж зөвлөх вэ?

Маш энгийн зөвлөгөө өгье гэж бодож байна. Эртнээс бэлтгэ, бүрэн зөв зөвлөгөө ав. Ингэснээр ирээдүйд визтэй холбоотой асуудал гаргахаас сэргийлэх юм. Өөрийнхөө урт хугацааны зорилготой нийцсэн сурах чиглэл, эсвэл карьерын замыг сонгоорой. Өөрийнхөө эрх, үүрэг хариуцлагыг ойлго, ялангуяа визний нөхцөлийн тал дээр. Ингэснээр цаг үргэлж хууль ёсны дагуу процессоо үргэлжлүүлэх боломж бүрдэнэ. Англи хэлний мэдлэг, чадвартаа хөрөнгө оруулснаар харилцааны тал дээр асуудал гарахгүй бөгөөд ингэснээр илүү сайн боловсрол эзэмших, сайн ажилтай, орон сууцтай болох боломжуудыг өөрийн болгоно. Хэрэв эргэлзэж байвал хууль эрхзүйн мэргэжлийн зөвлөгөө авах хэрэгтэй. Тэгвэл хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэж, стрессээс зайлсхийнэ.


Австрали бол зочломтгой, олон соёл бүхий улс юм. Хэрэв бэлтгэлээ сайн хангаж чадвал монголчууд манай улсад боловсрол, ажил мэргэжил, хувь хүний тал дээр өндөр амжилт гаргах боломжтой. Gentoo Lawyers-ийн хамт олон таныг Австралид амжилттай, найдвартай ирээдүй рүү хөтлөхөд үргэлж бэлэн байх болно. ■



SUMMIT COMPUTER TECHNOLOGY

БАЙГУУЛЛАГЫН ХУРЛЫН ӨРӨӨНИЙ ЦОГЦ ШИЙДЭЛ

Шинэ EDLA сертификатай BenQ Board Pro RPO4 нь BenQ-ийн техник, програм хангамжийн хүчийг Google-ийн албан ёсны үйлчилгээнүүдтэй хослуулснаар уулзалтын өрөөнд хамгийн өндөр түвшний бүтээмжийг авчирна.



BenQ Board Pro 04

BenQ Ухаалаг дэлгэц

ЭНТЕРПРАЙЗ



Ажилтнуудад ээлтэй интеграцчилсан шийдлүүд

eyesafe
CERTIFIED 2.0

Eyesafe®
Certified
2.0



TÜV
Certified



Air
ionizer



Air quality
sensor



BenQ Board Pro нь Eyesafe® Certified 2.0 гэрчилгээгээр баталгаажсан. RPF® 50 зэрэглэлтэй бөгөөд дэлгэцийн хөх туяаг өндөр хэмжээгээр бууруулснаар нүдийг ядрахаас хамгаалдаг.

Мөн TÜV болон SGS гэрчилгээтэй агаар цэвэршүүлэгч, агаарын чанарын мэдрэгч зэрэг ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарсан шийдлүүдтэй.





Provita

Yogurt



Нарийн тоосонцрын
харшлын шинж
тэмдгийг
дарангуйлна



Хоол
боловсруулах
системийг
дэмжинэ



Ашигтай
бактеритай
амьд йогурт

